

УВС АЙМГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ХӨТӨЛБӨР
/2008-2021 он/

УДИРТГАЛ

“Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр” нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм дэх хүний хөгжлийг хангахад чиглэсэн ирэх арван гурван жилийн хөгжлийн бодлогыг Монгол улс, Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөртэй нягт уялдуулан цогцоор тодорхойлсон баримт бичиг мөн.

ЗОРИЛГО

Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогод суурилсан Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөрийн зорилго нь иргэдийнхээ хөгжлийг дэмжих замаар мэдлэгт суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангаж, өндөр технологи бүхий байгаль орчинд халгүй үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэн хүний эрх, эрх чөлөөг дээдэлж өөрийгөө санхүүжүүлж, бие даан амьдрах чадвартай болон хөгжихөд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, Увс аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, Мянганы хөгжлийн стратегийн онол практикийн хандлагууд зэрэг баримт бичгүүдийн үзэл санааны дагуу энэхүү хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамруулан хэрэгжүүлэхээр тооцсон болно.

**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА,
ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

Алсын хараа

Эрдэм боловсролыг дээдлэн, үндэснийхээ өв уламжлал, соёл зан заншлыг эрхэмлэн хөгжил дэвшлээ өөрсдийн оюун ухаан хүч хөдөлмөрөөр бүтээж, эв зетэй, элбэг хангалуун аюулгүй амьдрах таатай орчинг цогцлон бүрдүүлэх

Эрхэм зорилго

Нийгэм, эдийн засаг, байгаль орчны бодлогын уялдааг ханган, аймгийнхаа олон ястан иргэдийн өвөрмөц ёс заншил, соёл иргэншлийн уламжлалт онцлогийг хадгалж дэд бүтцээ сайжруулан, мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай болгож, хүний хөгжлийн үзүүлэлтийг хөгжингүй орны түвшинд хүргэж, Монгол улсын хөгжилд нөлөө бүхий аймаг болох явдал мөн.

Увс аймгийн эрхэмлэх үнэт зүйлс

Хууль ёсыг эрхэмлэн дээдэлнэ
Олон ястны өлгий нутгийнхан эвтэй найрсаг амьдарна
Аймгаа хөгжүүлэх үйл хэрэгт хүн бүрийн хичээл зүтгэлийг чухалчилна
“Төрөлх нутгийнхаа сайн сайхны төлөө” гэсэн чин эрмэлзлэлийг төлөвшүүлнэ

Тэргүүлэх чиглэл

1. Боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгаалал, халамжийн үйлчилгээг боловсронгуй болгон гэр бүл төвтэй оюунлаг хүний хөгжлийг хангах
2. Аймгийн санхүүгийн удирдлага хяналтыг сайжруулан, эдийн засгийн хувьд бие даан өөрийгөө санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлэх
3. ХАА, байгалийн гаралтай экспортын баримжаатай боловсруулах аж үйлдвэрийг экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөгжүүлэх
4. Геологийн хайгуулын ажлыг эрчимжүүлж уул уурхай, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх
5. Эрчимжсэн МАА, газар тариалан, аялал жуулчлал хөгжүүлэх, жимс, чацаргана, давс зэргийг боловсруулж бренд бүтээгдэхүүнтэй болох
6. Эрчим хүч, зам тээвэр, харилцаа, холбоо мэдээлэл, барилгын салбарын үйлчилгээг хүртээмжтэй болгож, хөгжлийн орчинг бүрдүүлэх
7. Хөрш орнууд болон дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын шинжлэх ухаан, технологийн ололтыг импортлох зорилтыг эрхэмлэх
8. Онгон дагшин байгалийнхаа тэнцвэрийг хадгалж зохистой ашиглаж, нөхөн сэргээхэд чиглэсэн бодлогыг иргэдийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх
9. Хувийн хэвшил хурдацтай хөгжих таатай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Нэгдүгээр бүлэг

ХҮН АМ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, халамжийн бодлого

Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Гэр бүл 3 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөх орчин нөхцлийг бүрдүүлэх;
- Хүн амд эрүүл аж төрөх, зан үйлийг хэвшүүлэх
- Нүүдлийн болон хагас суурин байдлаар амьдарч буй алслагдсан бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлж хүн амын нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг тогтвортой сайжруулах замаар төрж, өссөн нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх;

Хүрэх үр дүн.

Хүн амын төрөлт нэмэгдэж, нас баралт, шилжих хөдөлгөөн буурч, дундач наслалт өндөрсөнө.

Стратегийн зорилт 2. Хүний хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлж, хүний хөгжлийн индексийг 0.720-аас бууруулахгүй байх. /2008-2021/

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгаж, шинэ зууны шаардлагыг хангасан оюунлаг иргэдийг төлөвшүүлэх
- Өрх бүрийг үйлдвэрлэгч болгон ажлын байр олноор бий болгох үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг нэмэгдүүлэх;
- Ёс зүй, сахилга, хариуцлагын төлөвшлийг төгөлдөржүүлэх
- Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд тэгш, чанартай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн.

Хүний хөгжлийн индексийг улсын дунджаас (дундач наслалт, нялхсын эндэгдэл г.м) доошгүй түвшинд хүргэнэ.

Стартеийн зорилт 3. Хүн амын орлогыг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах /2008-2015/

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Өрх, хүн амын бүртгэлийг сайжруулж ядуурлын мэдээллийн сан байгуулж амьжиргааны түвшинг тогтоон, мэдээллийг тогтмол шинэчилж байх

Хөдөлмөр эрхлэлт, зуучлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажиллах хүчний хөгжилд анхаарч тэднийг мэргэшүүлэх, чадваржуулах арга хэмжээг тууштай зохион байгуулж, үйлчилгээг малчид, албан бус болон бусад салбарт ажиллагсдад чиглүүлэх;

Ажил олгогчийг дэмжин хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний дэд бүтцийг бий болгох
Орлогын дахин хувиарлалтыг боловсронгуй болгох
Олон улсын төсөл хөтөлбөрт идэвхтэй хамрагдах

Хүрэх үр дүн

Ядуурлыг 2000 оныхоос 2 дахин бууруулна

Стратегийн зорилт 4. Аж ахуй эрхлэлт, ур чадвар, санхүү менежмент ба зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх замаар ядуурлын түвшинг эрчимтэй бууруулах /2016-2021/

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ ба үндсэн эрхийг хамарсан эрх зүйн орчинг бий болгох
- Өсөлтийн стратеги ба байнгын тогтвортой ажлын байр бий болгох
- Албан бус эдийн засаг дахь ажилчдыг зохион байгуулан төлөөллийг нь нэмэгдүүлж нийгмийн түншлэлийг бий болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг давтан сургах, дадлагажуулах, мэргэшүүлэхэд төрөөс дэмжиж ажиллах

Хүрэх үр дүн.

Жилд дунджаар 1500 гаруй байнгын, тогтвортой ажлын байр бий болж, ажилгүйдэл, ядуурлын түвшин буурч ажилгүйдлийн түвшин 3.0 хувьд хүрсэн байна.

Стратегийн зорилт 5. Хүүхэд, залуусыг хөгжүүлэхэд чиглэсэн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлчилгээг жигд хүртэх боломжийг олгох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

1. Хүүхдийн хөгжлийг хангах зорилгоор хэрэгжүүлж буй нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийг аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх
2. Хүүхэд бүр анхаарал халамж хүртэж, эсэн мэнд өсөж бойжих, сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх
3. Өсвөр үе, залуучуудыг албан ба албан бус боловсрол, мэргэжил олгох сургалтанд хамрагдах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих орчинг бий болгох;
4. Залуу гэр бүл орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах боломжийг өргөжүүлж, шинээр гэр бүл болсон залуус бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх
5. Увс аймгийн хүүхэд залуучуудын хөгжлийн төв буюу “Хүүхэд залуучуудын ордон” барьж байгуулах, хүүхдийг хөгжүүлэх сургалт, мэдээлэл, урлаг, спорт, соёлын олон талт үйл ажиллагаа явуулж, ордны барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан зам, шат зэргийг шийдвэрлэх.
6. Увсын хүүхдүүдийн хийж чадах зүйлийн жагсаалт гаргаж хэрэгжүүлж ажиллах
7. Хүүхэд эрүүл агаарт амран бие бялдраа хөгжүүлж, харилцан суралцаж, хамтран хөгжих хүүхдийн зусланг ажиллуулж, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхэлж буй, сургууль завсардсан, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд багачуудыг хамт олны дунд өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжүүлэн төлөвшүүлэх
8. Хүүхдийн урлагийн тайлан тоглолт болон уран бүтээлийн үзэсгэлэнг аймаг, улс, бүсийн хэмжээнд зохион байгуулж тогтмолжуулах
9. Улаангомд хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн байгуулж ажиллуулах

Хүрэх үр дүн.

- 9.3. Хүүхэд, залуус өв тэгш хөгжих орчин, аливаа үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авах орчин бүрдэнэ.
- 9.4. Увсын хүүхдүүд” гэх өнгө төрхийг илтгэсэн оюун ухааны болон бие бялдрын хөгжил, хүмүүжил төлөвшлийг шингээсэн иргэн бий болгоно

Стратегийн зорилт 6., Хүүхдийн эрхийг дээдлэн хамгаалж, эрхийг нь зөрчихгүй байх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хүүхдийн эрхийг гэр бүл, албан байгууллага, аж ахуйн нэгж, нутгийн удирдлагын байгууллагууд ямагт дээдлэн хамгаалах

- Бүх хүүхдийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, оношлогоо эмчилгээ хийж байх,
- Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэмт хэрэгт холбогдож буй болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн өмгөөлөл, нийгмийн хамгаалалыг сайжруулах
- Хүүхдийн эрхийн талаарх сургалт, сурталчилгааг өргөжүүлж, хүүхдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа, этгээдтэй хатуу тэмцэж, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх

Хүрэх үр дүн.

Увс аймаг хүүхдээ дээдэлж, хамгаалж чаддаг, хүүхдийн эрхийг зөрчдөггүй, хүүхдэд ээлтэй аймаг болсон байна.

Стратегийн зорилт 7. Гэр бүл, байгууллага, хамт олон, салбарын болон хүүхдийн хамтын ажиллагааны уялдаа холбоог хангасан, мэдээллийн сүлжээг бий болгож ашиглах, хүүхдийн өөрийн байгууллагыг дэмжин хүүхдийн оролцоог тогтвортой хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Хүүхдийн төлөө санд хөрөнгө хуримтлуулах
- Хүүхдийн элч нарын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх замаар хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд тусгайлан зориулсан үр дүнтэй, тогтвортой ажиллагаа бүхий арга хэмжээг хэрэгжүүлэх
- Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Хүүхэдтэй ажилладаг зөвлөх, хүүхдийн анд нөхөр, сайн дурын ажилтны чадавхийг бэхжүүлж, улмаар хүүхдийг чадваржуулах арга барилд сургах, мэдээллээр хангах, нэр хүндийг нь өргөх
- Аймгийн хүүхдийн чуулганыг 2 жил тутамд зохион байгуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах

Хүрэх үр дүн.

- Айл өрх, албан байгууллага, засаг захиргааны байгууллагуудын “Хүүхдийн төлөө” гэсэн хамтын ажиллагаа бэхжиж тогтворжсон байна.
- Хүүхдийн оролцоо хангагдаж, тэдний дуу хоолой шийдвэр гаргах түвшинд хүрч, хүүхэд, насанд хүрэгчдийн хамтын ажиллагаа, тогтолцоо нь хөгжин бэхжсэн байна.

Стратегийн зорилт 8. Нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд чиглэсэн халамж, үйлчилгээг сайжруулах /2008-2021/

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг хүрэх ёстой эзэнд нь хүргэх, уг үйл ажиллагаанд иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх
- Баруун бүсийн ахмадын асрамжийн төвийг байгуулж, стандартын хэмжээнд ажиллуулах, ахмадын сувиллын үйл ажиллагаа, ахмад настнуудад үзүүлэх нийгмийн халамж, эрүүл мэнд, гэрийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг өргөжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тэдэнд үзүүлэх эмнэлэг, боловсрол, халамж, нөхөн сэргээх үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн.

Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах иргэдийн тоо буурч, зайлшгүй халамж үйлчилгээ үзүүлбэл зохих иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар дээшилнэ.

Стратегийн зорилт 9. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх замаар иргэдийн нийгмийн хамгаалал, даатгалын үйлчилгээг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Нийгмийн даатгал, татварын байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах, ажил олгогчоос татвар, шимтгэл төлөхөөр мэдүүлсэн орлого, орон тоо, цалингийн сангийн мэдээлэл солилцон даатгалд хамрах хүрээг нэмэгдүүлэх
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг эрүүл мэндийн болон тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд бүрэн хамруулах
- Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл, тэтгэврийн даатгалын нэрийн дансны мэдээллийг даатгуулагч бүрээр бүрэн цэгцлэх

- Нийгмийн даатгалын байцаагчдын чадавхийг бэхжүүлж, даатгуулагчдад үйлчилгээ үзүүлэх чадварыг дээшлүүлж, шимтгэлийн талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн ач холбогдлыг сургалт сурталчилгааны бүх хэлбэрээр олон нийтэд таниулах

Хүрэх үр дүн.

Нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн чадавх нэмэгдэж, нийгмийн даатгалд хамрагдаагүй /нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах/ иргэдийн тоо буурч, үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

2, Боловсролын бодлого

Стратегийн зорилт 1. Хүүхдийг сургуулийн өмнөх наснаас нь эхлэн боловсролд жигд тэгш хамруулж сургуулийн насны хүүхдүүд суурь боловсрол заавал, цаашид бүрэн дунд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Ерөнхий боловсролын сургуулийн байршил, бүтэц, хэв шинжийг оновчтой тогтоох
- Ахлах ангид элсэгчдийн хүйсийн харьцааг улс, олон улсын түвшинд хүргэж тэнцвэртэй байлгах
- Суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах нөхцөл бүрдүүлэх
- Иргэдийн хэрэгцээнд суурилсан албан бус боловсролын үйлчилгээ чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтанд хамруулах тогтолцоог боловсронгуй болгох
- Суурь боловсрол эзэмшигчдийн 80-аас доошгүй хувь нь дараагийн шатны сургалтанд хамрагддаг болох
- 10-49 насны бүх иргэд бичиг үсгийн боловсролтой болж бичиг үсэг үл мэдэгчгүй аймаг болох
- Улаангом коллежийн үйл ажиллагааг мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд түлхүү чиглүүлж хөдөө аж ахуй, барилга, уул уурхайн салбарын инженер техникч, аялал жуулчлал, буудлын менежер бэлтгэх чиглэлийн сургалтын хүрээг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн

Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж байж сургуульд элсдэг болгож ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн чиг баримжаа олгодог болсон байна.

Стратегийн зорилт 2. Сургалтанд орчин үеийн дэвшилттэй технологи ашиглах нөхцөл бүрдүүлж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, сургалтын чанарт ахиц дэвшил гаргах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Сургалтаас самбар шохойг халж электрон хэлбэрээр явуулдаг болох
- Хөрвөх чадвартай багш бэлтгэх, мэргэшүүлэх
- Багш сурагч бүрийг компьютертэй болгох
- Бүх сургууль цэцэрлэгт интернетийн үйлчилгээ хүргэх
- Суралцагч бүр электрон сурах бичигтэй болох
- Сурлагын хоцрогдлыг арилгаж стандарт хангалтыг бага боловсролд 100 хувь, суурь ба бүрэн дунд боловсролд 90-ээс доошгүй хувьд хүргэх
- Гадаад хэл, математик, мэдээлэл зүй, байгалийн ухааны сургалтаар улсад тэргүүлж буй амжилтаа бататгах
- Улсын төрөлжсөн олимпиад, багш нарын ур чадварын уралдаан, тэмцээнд багш, сурагчид бэлтгэлээ бүрэн хангаж, эхний байр эзлэх хөшүүргийг бий болгох

Хүрэх үр дүн

Ерөнхий боловсролын сургуулийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сургалтыг олон улсын жишигт нийцүүлэн явуулж, хүүхэд бүр боловсролын үйлчилгээг жигд тэгш хүртдэг болж, стандарт хангалт 90-100 хувьд-д хүрсэн байна.

Стратегийн зорилт 3. Иргэн бүр боловсролын үйлчилгээг жигд тэгш хүртэх орчин бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- 2000 оноос хойш их засвар хийгдээгүй сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгад их засвар хийж дулаан хангамжийг шийдэх
- Стандартын бус барилгатай цэцэрлэгүүдийг зориулалтын барилгатай болгох
- Улаангомд хичээлийн байрны суудал, цэцэрлэгийн орны тоог нэмэгдүүлж одоогийн ачааллыг 2 дахин багасгах
- Сургууль цэцэрлэгийг орчин үеийн тоног төхөөрөмж техник хэрэгслээр бүрэн хангах
- Сургууль цэцэрлэгийн хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх
- Сум бүр боловсролын сантай, өөрийн орлогын эх үүсвэртэй болж ажиллагчдын нийгмийн асуудлыг ээлж дараатай шийдвэрлэх

Хүрэх үр дүн

Сургалтын материаллаг орчин бүрдэж, санхүүгийн орчин сайжирсан байна.

Стратегийн зорилт 4. Орон нутагт хэрэгцээт мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх давтан сургах тогтолцоог бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Сум байгууллага бүр хэрэгцээт боловсон хүчнээ захиалгаар бэлтгэж сургадаг болох
- Аймаг орон нутгийн хөгжилд хэрэгцээтэй зарим боловсон хүчнийг гадаадад бэлтгэн сургах
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх давтан сургах аймгийн тогтолцоотой болох
- Багш нарыг мэргэжлээрээ сэлгэн ажиллах чадвартай болгох
- Багш нарыг 5 жил тутамд төвлөрсөн, 3 жил тутамд орон нутгийн ба бүсийн сургалтанд хамруулдаг болох
- Эмч, багш, инженер, технологийн чиглэлээр зайлшгүй шаардлагатай мэргэжилтэнг гадаадын өндөр хөгжилтэй оронд сургаж бэлтгэх
- Багш нарын мэргэжлийг ажлын байран дээр нь дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх.

Хүрэх үр дүн.

Аймгийн хэмжээнд ирээдүйн боловсон хүчнийг бодлоготой бэлтгэн, орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 5. Боловсролын өнөөгийн тогтолцоог нийгмийн шинэ харилцаанд зохицуулан боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Иргэд суралцагчид боловсролын үйлчилгээг өөрийн хэрэгцээнд нийцүүлж сонгож авах нөхцөл бүрдүүлэх

Боловсролын үйлчилгээг олон хувилбартай хүртээмжтэй болгох

Иргэд суралцагчдад хүрэх боловсролын үйлчилгээ тасралтгүй байх

Хүрэх үр дүн.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид судлах хичээл болон хичээл заалгах багшаа өөрөө сонгодог боломжтой болсон байх

Стратегийн зорилт 6. Шинжлэх ухааны байгууллагын үйл ажиллагааны чадавхи, хамтын ажиллагааг хөгжүүлж эрчимжүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Аймгийн хэмжээнд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төвийг шинээр байгуулан ажиллуулах
- Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн дагуу судлаач шинжээчдийн баг ажиллуулан, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх сан бий болгон жил бүр аймгийн төсвийн тодорхой хувиар санхүүжилт хийдэг эрх зүйн үндэс бий болгох
- Газар тариалангийн болон техник технологийн чиглэлээр их дээд сургууль байгуулж шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллах
- Хэрэглээний нанотехнологи хөгжүүлж энэ чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийнхөөс харьцангуй өндөр түвшинд хүргэх

- ШУТ-ийн чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудтай ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, зайлшгүй шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх ажлыг эрчимжүүлэх

Хүрэх үр дүн

Шинжлэх ухааны салбарын дэвшилтэт технологийн үр дүн аймгийн хөгжлийн нэг тулгуур хүч болсон байна.

3, Эрүүл мэнд, биеийн тамир спортын бодлого

Стратегийн зорилт 1. Хүн ам эрүүл аюулгүй, тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Эрүүл аж төрөх зан үйлийг хүүхдэд бага наснаас нь дадал хэвшил болгох
- Хүүхдийг эхийн хэвлийд байхад эрүүл мэндийн байдалд урьдчилан оношлогоо хийж удмын санг эрүүлжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- НЭМ-ийн сургалтын хэрэгцээг тогтоох судалгаа хийж, нотолгоонд тулгуурлан мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах технологийг нэвтрүүлэх
- Эмнэлгийн хог хаягдлыг ангилж устгах стандартын шинэ технологи нэвтрүүлэх.

Хүрэх үр дүн.

Аймгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд аюулгүй, сөрөг нөлөөгүй орчин бүрдэх үндэс суурь тавигдана.

Стратегийн зорилт 2. Эх хүүхдэд ээлтэй аймаг болох чиглэл баримтлан мянганы зорилтын түвшинд хүргэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг иргэн гэр бүл, эрүүл мэндийн байгууллага, төрийн ба ТББ–ын хүрээнд зохион байгуулах
- Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хүртээмж, чөлөөт сонголт хийх боломжийг нэмэгдүүлж хүсээгүй, амь насанд эрсдэлтэй жирэмслэлт, аюултай үр хөндөлтийг бууруулах
- Эх, хүүхдийг хоол хүнс, бичил тэжээл, аминдэмээр хангах үйлчилгээний төвүүдийг стандартчлан төрөөс дэмжих систем бүрдүүлж ажиллах
- Нэн ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй эх, хүүхдийн сувилал байгуулж ажиллуулах
- Хүүхдийн эндэгдэлд тэргүүлэх байр эзэлж байгаа төрөх тойрны өвчний оношлогоо, эмчилгээнд орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлэн зохион байгуулалтын өөрчлөлт хийх
- Хүүхдийн эмнэлэг шинээр барьж шаардлагатай багаж тоног төхөөрөмж, мэргэжлийн эмч, хүний нөөцөөр хангах

Хүрэх үр дүн.

Эх хүүхдэд ээлтэй үйлчилгээний орчин бүрдэж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайжирч, эх нялхасын эндэгдэл тууштай буурсан байна

Стратегийн зорилт 3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой арга сонгон хэрэгжүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Эрүүл мэндийн байгууллагуудад иргэдэд тусламж үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, хүргэх нөхцлийг бүрдүүлэх
- Эмнэлгийн дотоод мэдээллийн сүлжээ болон өвчний цахим түүх нэвтрүүлэх
- I-II шатлалын эмнэлгүүдэд алсын зайн оношлогоо, зөвлөгөө сургалт, электрон номын сан, худалдааг нэвтрүүлж, III шатлалын болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдээс тусламж, зөвлөгөө авах сүлжээг бий болгох
- Зөвлөх поликлиникиг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах
- Нарийн мэргэжлийн нэн яаралтай тусламжийг иргэдэд газар дээр нь үзүүлдэг яаралтай тусламжийн баг ажиллуулах
- Эмийн бус, уламжлалт, нөхөн сэргээх эмчилгээг түлхүү хөгжүүлэх
- Алслагдсан нутгийн эмзэг бүлгийн иргэдэд явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлэх

- Эмнэлгийн боловсон хүчнийг орчин үеийн тоног төхөөрөмжийг ажиллуулах чадвартай болгох
- Хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгааныг илрүүлэх судалгааны төвтэй болж, анагаах ухааны эмчилгээ сувилгааны шилдэг технологийг шатлалын эмнэлэгүүдэд нэвтрүүлж үр дүнг тооцох
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллага, иргэдийг нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй, найдвартай хангах

Хүрэх үр дүн.

Иргэд үйлчилгээ авах эмнэлэг, эмчээ өөрөө сонгох нөхцөл бүрдүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, сэтгэл ханамж сайжирна

Стратегийн зорилт 4. Нийгмийн нөөц бололцоог үр дүнтэй дайчлан халдварт өвчний өвчлөл эндэгдлийг бууруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Эмнэлгээс шалтгаалсан халдварт өвчний оношлогоо эмчилгээ сэргийлэлтэнд орчин үеийн шинэ технологи арга барилыг ашиглах
- Байгалийн голомтот халдварт өвчний эпизот, ахуйн шавьж мэрэгчийн тархалтыг судлан тогтоож, тэмцэх арга барилыг сайжруулан, шинэлэг үр дүнтэй технологийг нэвтрүүлэх.
- БЗДХ/ХДХВ/ДОХ-ын харуулдан тандах тогтолцоог нэвтрүүлж оношлогоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлж, үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн таатай орчинг бий болгох
- Шууд хяналттай богино хугацааны сүрьеэгийн эмчилгээг эрүүл мэндийн үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн.

Халдварт өвчний дэгдэлтийн мөчлөгтэй уялдуулан өвчлөл, эндэгдэлийг жилээс жилд бууруулна.

Стратегийн зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, санхүүжилт, боловсон хүчний хангамжийг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Орчин үеийн техник технологийг бүрэн эзэмшсэн мэргэжлийн өндөр ур чадвартай, салбарын ёс зүйн хэм хэмжээ төлөвшсөн хүний нөөцийг бүрдүүлэх
- Сум, сум дундын эмнэлгийг стандартын дагуу мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж ажиллаж амьдрах орчин бүрдүүлэх
- Эрүүл мэндийн чанарын удирдлага, санхүү, мэдээллийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлэн, удирдлагын шинэ барилыг дэмжих
- Өрхийн болон сумын эмнэлгийг санхүүжүүлдэг механизмыг боловсронгуй болгох асуудлуудыг Засгийн газар, харъяалагдах яам агентлагуудад тавьж шийдвэрлүүлэх

Хүрэх үр дүн.

Эрүүл мэндийн байгууллага салбарын стандартыг мөрдөн ажиллах боломж бүрдэнэ.

Стратегийн зорилт 6. Үндэсний спорт тоглоом наадгайг шинэ төрлүүдээр баяжуулан нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх .

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Хүн амын дунд хөгжих боломжтой биеийн тамир спортын төрлүүдийн таатай орчин бүрдүүлж, боловсон хүчнээр ханган, материалаг баазыг бэхжүүлэх
- Аймгийн хэмжээнд амжилт гаргаж болохуйц спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх
- Нийтийн биеийн тамир спортын ажил үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэж, авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглүүлэх
- Үндэсний спортын төрлийг монгол туургатан, гадаад оронд сурталчлах зорилгоор сурталчилгааны материал, гарын авлага, CD, DVD бичлэг хийж түгээх
- Өсвөр үеийн шигшээ багийг тодорхой төрлүүдээр байгуулан, урамшил олгож, үр дүнг тооцох
- Уралдаан тэмцээнд оролцогчдын аюулгүй байдал, орчны стандартыг мөрдүүлэх
- Биеийн тамир спортын холбоо, клуб, нийгэмлэгийн ажиллагааг идэвхжүүлэн, дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн.

Уралдаан, тэмцээнд оролцох спортын төрөл тамирчдын тоо нэмэгдэж амжилтын чанар дээшилж, хүн амын дундахь зүрх судас, бодисын солилцооны өвчлөл багасна.

Стратегийн зорилт 7 Өсвөр үеийнхэн болон залуучуудын бие бялдарын хөгжлийг дээшлүүлж, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Төрөл бүрийн спорт соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах стандартын зам талбай бүхий цэнгэлдэх хүрээлэнтэй болох

Сонгон хөгжүүлж байгаа спортын төрлүүдэд тохирсон материаллаг баазыг шаардлагын түвшинд хүргэх

Сургуулийн өмнөх насны болон ЕБС-ийн биеийн тамир эрүүл мэндийн хичээлийн үр өгөөж, багш нарын мэдлэг чадварыг сайжруулах

Хүн амын бие бялдарын өсөлт хөгжилтийн судалгааг тогтмол хийж судалгааны дүнд тулгуурласан дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлж үнэлгээг ахиулах

Хүрэх үр дүн

Спортын материаллаг бааз сайжирч, хүүхэд залуучуудын бие бялдарын өсөлт хөгжилт хэвийн явагдана

4. Соёл, урлагийн бодлого

Стратегийн зорилт 1. Ойрадын олон ястны өвөрмөц өв соёл, уламжлалыг судлан шинжлэх, хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх, сурталчлах, олон ястны урлагийн баялаг өв санг орчин үеийн урлаг соёлын ололттой нягт уялдуулан өөрийн өнгө төрхтэй болгон хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаангом хотод Ойрадын соёлын цогцолбор байгуулах
- Баруун монголын олон ястны дуу хуур, туульс, ерөөл магтаал, бий биелгээ, уртын дуу, хэл яриа, үгсийн сан хөмрөгийн мартагдсан болон мартагдах гэж буй өв санг судлах, сэргээх, патентлан хадгалах, урлагийн эргэлтэнд оруулах, өвлөн уламжлуулах зэрэг ажлыг дагнан хариуцдаг эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй болох
- Баруун монголын олон ястны дуу хуур, ерөөл магтаал, бүжиг, бий биелгээний арвин өв санг урын сангийн үндсэн бааз суурь болгож, ойрад түмний гэх өвөрмөц дүр төрхийг бий болгох
- Олон ястны онцлогийг тодотгон харуулах зорилгоор баяд, дөрвөд, хотон, элжгэн халх ястны язгуур урлагийн наадмыг 4 жил тутам зохион байгуулах
- Монгол Улсын соёлын тухай хуулинд заасан иргэний журамт үүрэг болох угийн бичиг хөтлөх журмыг айл өрх бүрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Хүрэх үр дүн.

Ойрадын олон ястны соёл, уламжлал сэргэж, өвлөн тээгчдийн хүрээ өргөжиж ойрад түмний гэх өвөрмөц түр төрх бий болгох.

Уртын дуу дуулах, морин хуур тоглох иргэдийн тоо нэмэгдэнэ

Стратегийн зорилт 2. Мэдээллийн нэгдсэн сүлжээ бүхий интернет номын сангуудтай болох, ном хэвлэлийн худалдаа үйлчилгээний сүлжээ бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мэдээллийн хүрээг өргөтгөн санг арвижуулах
- Төв номын санг мэдээлэл үйлчилгээний төв болгож, сумдын номын санг мэдээлэл үйлчилгээний сүлжээнд хамруулах
- Ном хэвлэлийн худалдааны сүлжээ байгуулах

Хүрэх үр дүн.

Номын санд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч, иргэдийн мэдээлэлд дэвшил гарсан байна.

Стратегийн зорилт 3. Аймгийн музейн үзмэрийг шинээр дэглэх, сумдын орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг бүрэн сэргээх, зориулалтын байраар хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Музейн үзмэрийг шинэ эд өлгийн зүйлээр баяжуулж, зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлэх
- Музейг эрдэм шинжилгээ сургалт сурталчилгааны төв болгож, бүх сумдын орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сэргээж, сургалт хүмүүжил, танин мэдэхүйн ажлыг хамтатган явуулдаг болох
- Аймгийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулан аялал, жуулчлал эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай холбож өгөх, интернетээр дамжуулан олон улсын хэмжээнд харилцан мэдээлэл солилцох боломж бүрдүүлэх

Хүрэх үр дүн.

Түүх соёлын дурсгалт өвийн судалгаа шинжилгээний үйл ажиллагаа жигдэрч, эрдэм шинжилгээ сургалт сурталчилгааны төвтэй болно.

Стратегийн зорилт 4. Соёлын байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх, соёлын төвүүдийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн хангалтыг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

- Соёл урлагийн мэргэжлийн байгууллагуудын ажиллах нөхцлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах
- Орон нутгийн театрт орчин үеийн шаардлагад нийцүүлэн мэргэжлийн хөгжмийн удирдаач, концертмейстер, бүжиг дэглээч, соёл урлагийн менежер зэрэг мэргэжлийн театрт байвал зохих боловсон хүчнийг бэлтгэх
- Соёлын байгууллагын бүтэц орон тоог үйлчилгээний чанар, хүртээмжээр тогтоох
- Соёлын байгууллагыг мэргэжсэн боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, чадваржуулах
- Орон нутгийн соёл, урлагийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтыг төвд болон орон нутагт нь зохион байгуулах арга хэмжээг тодорхой цаг хугацаанд үе шаттай авч хэрэгжүүлэх
- Аймаг сумдын соёлын байгууллагуудын хөгжмийн зэмсэг, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гадаадын зээл тусламж, төсөлд хамруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн

Соёл, урлагийн мэргэжилтэй боловсон хүчний залгамж чанар хадгалагдаж, техник тоног төхөөрөмжийн хангалт жигдэрсэн байна.

Хоёрдугаар бүлэг

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.Эдийн засгийн нэгдсэн бодлого

Хөгжлийн үе шатны зорилтууд

1-р үе шат 2008-2015 он.

Зорилт: Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийн хөгжилд түлхүү анхаарч, байгалийн баялгийг боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, тогтвортой өсөлтийг ханган, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 4 сая төгрөгт хүргэнэ. Төсвийн зардлын дийлэнхи хувийг өөрийн орлогоор санхүүжүүлэх эдийн засгийн суурь, боломжийг бүрдүүлнэ.

2-р үе шат 2015-2021 он.

Зорилт: Төсвийн зардлын ихэнхи хувийг өөрийн орлогоор бүрдүүлж, эдийн засгийн хувьд бие дааж өөрийгөө санхүүжүүлэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 9.5 сая төгрөгөөс багагүй хэмжээнд хүргэнэ.

Стратегийн зорилт 1. Төсвийн төлөвлөлтийг Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөрт нийцүүлэн үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжилд илүүтэй чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төсвийг Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан боловсруулах.
- Орон нутгийн төсвийн орлогыг тогтвортой нэмэгдүүлэх, төсвөө бие даан бүрдүүлэхэд чиглэсэн цэгцтэй бодлогыг хэрэгжүүлснээр төсвийн зарлагын 60-аас доошгүй хувийг өөрийн орлогоор санхүүжүүлдэг болох.
- Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож орон нутгийн төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах

Хүрэх үр дүн:

Санхүү, төсвийн удирдлага сайжирснаар хариуцлагын тогтолцоо өндөржиж, төсвийнхөө тодорхой хэсгийг өөрийн орлогоор санхүүжүүлэх чадвар бүхий экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ тогтворжсон эдийн засагтай болсон байна.

Стратегийн зорилт 2. Төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөртэй оновчтой уялдуулж, урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төсвийн хөрөнгө оруулалтыг зорилтот хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, төслүүдэд тулгуурлан хуваарилах.
- Аймгийн эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц нөлөөлөх чадвартай, тэргүүлэх чиглэлийн ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах, геологи хайгуулын ажлыг идэвхижүүлж, газрын хэвлийн баялгийн нөөцийг тогтоох, олборлох, боловсруулах ажлыг эрчимжүүлэх.
- Шинэ технологид суурилсан бүтээмж сайнтай, уул уурхайн болон бусад боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах
- Үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх, ажиллах хүчний багтаамж өндөртэй, өөрийн түүхий эд, бусад давуу талд тулгуурласан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлэх. Тэдний бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл болон бусад боломж, нөхцлийг бүрдүүлэх
- Тэргүүлэх чиглэлд тусгагдсан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгох.
- Усалгаатай газар тариалан эрхлэхэд тохиромжтой үржил шимт хөрс, уламжлалт арга туршлага, материаллаг баазуудыг түшиглэн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн, өндөр ашиг шимт мал амьтныг өсгөн үржүүлэхийг хөрөнгө оруулалтаар дэмжих.
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Мэдээлэл холбооны орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог сайжруулах.
- ХАА, уул уурхайн салбарт лизинг, түрээсийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах.

Хүрэх үр дүн:

Төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой хуваарилснаар цаашид хөгжих эдийн засгийн бааз суурийг бий болгоно.

Стратегийн зорилт 3. Төвөөс алслагдмал бүс нутгийн хэмжээнд экспортын баримжаатай импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эдийн засаг, санхүүгийн хөшүүргүүдийн тусламжтайгаар материал баялгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын энэ талын туршлагыг бүтээлчээр хэрэглэх

- Эрдэс, түүхий эд, ноос ноолуур, мах, сүү, арьс шир боловсруулах салбарын үйлдвэрлэлд шинэлэг технологи нэвтрүүлэх, импортоор авдаг зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх.
- Цахим зүйн болон оюуны багтаамж өндөртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
- Экспортын баримжаатай үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын салбар, орон нутгийн “брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох.
- Өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэрлэлд тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, боловсруулах бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд гаалийн тарифын бодлогыг чиглүүлэх
- Хандгайтын боомтод эдийн засгийн худалдааны чөлөөт бүсийг байгуулах

Хүрэх үр дүн:

Орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн экспортын чиглэлтэй, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ өснө.

Стратегийн зорилт 4 Банк, санхүүгийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Банкны байгууллагаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх,
- Сумдад арилжааны банкуудын салбарыг нээн ажиллуулж өрсөлдөөнийг нэмэгдүүлэх
- Арилжааны банкуудтай зөвшилцөж эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ авах
- Зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлснээр зээлийн хүүг эрэлт, нийлүүлэлттэй оновчтой уялдуулан бууруулж, банкны эрсдэлийг бууруулах.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцжуулах зориулалт бүхий зээлийн хүүг бууруулж, хугацааг нь уртасгах.
- Аж ахуйн нэгжийн тооллогыг 3 жил тутам явуулж тооллогын дүнгээр мэдээллийн бааз сан үүсгэн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулж орлого тооцох боломжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн:

- Банк, санхүүгийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэнэ. Иргэд үнэт цаасны арилжаанд чөлөөтэй оролцож орлогоо нэмэгдүүлнэ.
- Зээлийн хүү буурснаар жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж, эдийн засгийн өсөлт бий болно.

Стратегийн зорилт 5: “Увс хүн”-ийг хөгжүүлж, өөрийн дотоод нөөц бололцоондоо түшиглэн аймгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ

Хэрэгжүүлэх арга зам:

- Аймгийн хүний нөөцийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх
- Иргэдээ амьдрах арга ухаанд байнга суралцуулж, үрэлгэн хэрэглээг халж, ухаалаг хэрэглээний механизмыг бий болгож хэвшүүлэх.
- Нарийн мэргэжлийн ажилтан ажилчдыг сургаж бэлтгэх сургалтын орчинг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд чухал хэрэгцээтэй, өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Оюутнууд болон ахмад настнуудыг хөдөлмөрийн нэмэлт орлого олох болоцоогоор хангах.
- Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулан ажиллуулж, өндөр технологи нутагшуулахыг эрмэлзэх.
- ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг сумдад байгуулах бодлогыг баримтлах.
- Хөрш зэргэлдээ улс, аймгуудын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд таатай орчныг бүрдүүлэх, гадаад дотоодын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг эрж олох, оновчтой байршуулах.
- Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, давхардалгүй, хөнгөн шуурхай болгоход чиглэсэн шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх.
- Бүх сумдыг эрчим хүч, холбоо, мэдээллийн сүлжээнд бүрэн хамруулах.

Хүрэх үр дүн:

- Ажиллах эрч хүч, эрмэлзэл дүүрэн, боловсрол мэдлэгээр баян, арга туршлагаар арвин, нутаг орноо хөгжүүлэх чин хүсэлтэй “Увс хүн”-ийг төлөвшүүлнэ.
- Сум бүр үйлдвэрлэгч болж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Зах зээлд өрсөлдөх чадвартай “брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болсон байна..

Стратегийн зорилт 6. Гадаад худалдааг нэмэгдүүлэх бодлого баримталж ажиллана
Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- ОХУ-ын Кеморово, Хакас муж улсын, БНХАУ-ын Алтай, Цонж аймгуудын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж гадаад худалдааны таатай орчин бүрдүүлэх
- Харилцагч муж улс, аймгуудтай худалдаа хийх хөнгөлөлттэй нөхцөл эдлэх чиглэлээр хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Экспортын хөнгөлөлт, тусгай нөхцөлийг бүрэн дүүрэн ашиглах
- Бүс нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны байгууллагуудын хүрээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулж, аймгийн экспортын бүтээгдэхүүний эзлэх байр суурийг өргөтгөх
- Аймгаас гаргах экспортын бүтээгдэхүүний тогтвортой нэр төрлийг бий болгох.
- Эдийн засгийн өсөлтөд тэргүүлэх ач холбогдолтой эрдэс түүхий эд, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортлох
- Мах, арьс шир, ноос, ноолуур зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эрүүл ахуйн болон дэлхийн стандартын шаардлага хангасан, экологийн цэвэр эцсийн бүтээгдэхүүний экспортлох.
- Аймгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэх зорилготой бүтээгдэхүүнийг импортлох .
- Байгаль орчинд халгүй, хаягдал багатай боловруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, уул уурхайн болон дэд бүтцийн салбарын орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжих

Хүрэх үр дүн

Экспорт, импортын бүтээгдэхүүний нэр төрөл олширч хэмжээ нэмэгдэн эдийн засгийн хөгжлийн нэг тулгуур үзүүлэлт болгоно

2, Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

2.1. Геологи, уул уурхайн салбарын хөгжлийн бодлого

Стратегийн зорилт 1. \2008-2015 он Аймгийн нутаг дэвсгэрт хийх геологи хайгуулын ажлыг нэмэгдүүлж, ашиглах нөөцийг бүрдүүлж, уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа :

- Геологийн судалгаа, эрдэс баялгийн эрэл хайгуулын ажлыг ялангуяа алт, нүүрс, давс бусад өнгөт, үнэт металлийн чиглэлд өргөтгөж, ашиглах нөөц орд газруудыг нэмэгдүүлэх
- Газрын тосны хайгуулыг эрчимтэй хийж нөөцийг тогтоох, ашиглах ажлыг эхлүүлэх
- Ашигт малтмалын орд газрыг ашиглаж аймаг, тухайн сумын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлыг бууруулахад түлхүү анхаарах
- Аймагт байгаа нүүрс, давс, алтны болон цэрд, шохой, төмрийн хүдрийн зэрэг барилгын материалын үндсэн түүхий эд үйлдвэрлэх эрдсийн ордуудыг тэргүүн ээлжинд ашиглах замаар эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж, санхүүгийн чадавхи, хуримтлал бүрдүүлэх.
- Уул, уурхайн хайгуул судалгаа, ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг зэрэгцүүлэн хийлгэж, нөхцлийг сайжруулах.
- Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандартыг мөрдүүлэх
- Хаягдал багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа уурхайг урамшуулах хөшүүргийг бий болгон мөрдөх.
- Гар аргаар ашигт малтмал ашиглах, олборлох ажлыг эрх зүйн дагуу журамлаж, зохион байгуулалтад оруулах

Хүрэх үр дүн:

- Аймгийн нутаг дэвсгэрийн 50-иас доошгүй хувьд геологийн судалгаа хийгдэж дүгнэлт гаргуулна.
- Эвдэгдсэн газрын нөхөн сэргээлтийн ажил хийгдэж, биологийн нөхөн ургалт сайжирна.

Стратегийн зорилт 2. \ 2016-2021 он Уул уурхай, ашигт малтмалын салбарт тэргүүний техник, технологийг эрчимтэй нэвтрүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эрдэс түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах хаягдалгүй, байгаль орчинд хал багатай, өндөр технологийг өргөн нэвтрүүлэх
- Хар тарвагатай, Шүдэн уул зэрэг уул уурхайн үйлдвэрийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх.
- Нүүрсийг боловсруулах технологийг эзэмшин, төрөл бүрийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, химийн үйлдвэрлэл хөгжүүлэх.

Хүрэх үр дүн:

Уул уурхайн салбарт тэргүүний техник, технологийг эрчимтэй нэвтрүүлнэ.

2.2. Боловсруулах аж үйлдвэр

Стратегийн зорилт 1. \ 2008-2015 он Боловсруулах аж үйлдвэрийн салбарт шинэ технологийг нэвтрүүлж, бүс нутгийн зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Өндөр технологийг нэвтрүүлж, дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах аж үйлдвэрийн шинэ салбаруудыг хөгжүүлж эхлэх
- Экспортын баримжаатай, өрсөлдөх чадвартай, нэмүү өртөгтэй, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг боловсруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дотоод, гадаад зах зээлд өрсөлдөх
- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглүүлж хөгжүүлэх.
- Үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулах, бүтээгдэхүүний загварыг шинэчлэх замаар гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх

Хүрэх үр дүн:

- Боловсруулах аж үйлдвэрт өндөр технологи нэвтэрч, үйлдвэрлэл өсч, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дээшилж, ДНБ-д салбарын эзлэх хувийн жин нэмэгдэнэ.
- Гадаад, дотоод зах зээлд өрсөлдөх чадвартай, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

Стратегийн зорилт 2. \ 2016-2021 он Аймгийн хөгжлийн дотоод, гадаад нөөц боломжтой оновчтой уялдуулан, импортыг орлох, нэмүү өртөг бүхий зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Өөрийн аймаг, суманд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний зарим барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах
- Олон улс, улсынхаа стандарт, чанарын шаардлагыг хангасан нэмүү өртөг бүхий экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
- Улаангом хотод үйлдвэрлэл технологийн парк байгуулах.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах болон арьс ширний үйлдвэрлэл, модны үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулж ажиллуулах

Хүрэх үр дүн:

Аймагт үйлдвэрлэл технологийн парк байгуулагдаж, импортыг орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ.

2,3. Жижиг, дунд үйлдвэрлэл

Стратегийн зорилт 1. \ 2008-2015 он Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг бүх талаар дэмжиж, ач холбогдлоор нь эрэмблэх, тэдгээрт үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж ажиллах
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээл, зээлийн даатгалын үйлчилгээнд хамруулах.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, сумдын бүсчиллийн дагуу тэргүүн ээлжинд хөгжүүлэх ЖДҮ-ийн жагсаалтыг гарган эрэмблэх, сумдын бүсийн төв Улаангом, Баруунтуруун, Өмнөговь, Сагил сумдад бизнес инкубаторийн салбарыг байгуулж ажиллуулах
- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн суурь үзүүлэлтэд эзлэх хувийг өсгөн, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлөхүйц хэмжээнд хүргэх арга хэмжээ авах

Хүрэх үр дүн:

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг тууштай дэмжиж, хөгжүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлснээр өрхийн үйлдвэрлэл нэмэгдэнэ.

3. Мал аж ахуйн салбарын бодлого

Стратегийн зорилт 1. | 2008-2015 он | Аймгийн мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төв суурин болон хүн амын нягтралтай газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт үхэр, хонь ямаа сонгон үржүүлэх, суурин, хагас суурин аж ахуй эрхлэхийг дэмжих
- Нутгийн үүлдрийн малыг өөр дотор нь шилж сонгон цэврээр үржүүлэхээс гадна шилмэл үүлдэр, омгийн малаар сайжруулах ажлыг зохион байгуулах
- Мал эмнэлгийн нэгжүүдийн материаллаг хангамжийг бэхжүүлэх,
- Мал эмнэлгийн салбарт хувийн хэвшлийг өргөжүүлж, өрсөлдөөн бий болгох замаар үйлчилгээний чанар, хуртээмжийг сайжруулах, боловсон хүчнийг чадавхижуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Сум бүр стандартын шаардлага бүрэн хангасан 2- оос доошгүй мал эмнэлэг, үржлийн аж ахуйн нэгжтэй болох
- Улсын хилийн боомтуудад мал эмнэлгийн хорио цээрийн хамгаалалтыг бэхжүүлж, мал амьтны халдварт өвчинг улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж, хамгаалах, газар авахуулалгүй эмчлэх
- Мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамжийг сайжруулж, лабораторийг олон улсын стандартын түвшинд хүргэх
- Малын өвчнийг эмчлэн эдгээх монгол уламжлалт аргуудыг залуу малчдад өвлүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах.
- Улаангом, Баруунтуруун, Тэс, Давст зэрэг сумдыг түшиглэн гахай, тахиа, зөгийн аж ахуйг хөгжүүлэх
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, эзэмшүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг үйлдвэр цех байгуулах, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх

- Хоршоо, нөхөрлөлийн тогтолцоонд тулгуурлан, мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд бэлтгэн нийлүүлэх борлуулалтын сүлжээг бий болгож “Арилжааны бирж”-ийг Улаангом хотод байгуулах
- Хөдөлмөрөө хоршиж ажиллах, малчдад үйлчлэх, зуучлах хоршоо, нөхөрлөл, бүлэг зэрэг сайн дурын байгууллагуудыг бий болгох ажлыг зохион байгуулж, мэдээлэл сурталчилгаа, мөнгө зээлийн бодлогын хүрээнд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх

Хүрэх үр дүн:

Мал аж ахуйн үйлдвэрийн бүтээмж нэмэгдэж, МАА-г эрчимжүүлэх таатай орчин бүрдэнэ.

Мал эрүүлжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болно

МАА-н үйлдвэрлэлд хамтын давуу тал нэвтэрч, ажлын бүтээмж дээшилнэ.

Стратегийн зорилт 2 | 2016-2021 он |Бэлчээрийн менежментийг сайжруулах, МАА-н үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бэлчээрийн даацад тохируулан малыг өсгөн үржүүлэх бодлого хэрэгжүүлэх, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх
- Төсөл хөтөлбөрүүдтэй үйл ажиллагаагаа нягт уялдуулан бэлчээр ашиглалт, цөлжилт, бэлчээрийн талхагдал, ургамлын бүтэцийн өөрчлөлт тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, малчдад ойлгуулах, сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулах
- Усны эх үүсвэргүй бэлчээрт шинээр худаг гаргах, ашиглагдахгүй байгаа худаг уст цэгийг сэргээн засварлах замаар бэлчээрийн хангамжийг нэмэгдүүлэх
- Бэлчээрийн хортон мэрэгчдийн судалгаа гаргах, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, газар, бэлчээрийн талхагдлыг бууруулах арга хэмжээ авах,
- Бэлчээрийг хувиартай ашигладаг уламжлалт аргыг сэргээн сум, баг, хот айлын түвшинд бэлчээр ашиглалтыг сайжруулах
- Тэжээлийн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх, уураг витаминт багсармал, холимог тэжээлийн үйлдвэрийг Тэс, Баруунтуруун, Тариалан сумын Хархираа багийг түшиглүүлэн сэргээн байгуулах
- Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах чадавхийг дээшлүүлж, бэлчээрийн ашиглалтын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Тэс, Баруунтуруун, Бөхмөрөн, Улаангом, Түргэн, Тариалан, Сагил сумдад хадлангийн механикжсан бригад салааг сэргээн байгуулах
- Хадлангийн талбайн усан хангамжийг нэмэгдүүлж, ургацын гарц, чанарыг тогтвортой нэмэгдүүлэх, царгас тариалалтыг нэмэгдүүлж, аймгийн нэрийн бүтээгдэхүүн болгох
- Бэлчээр усжуулах, усалгаатай нөхцөлд тэжээлийн олон наст ургамал тариалах, үйлдвэрлэх, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх
- Баруунтуруун, Хархираа, Улаан хотгорын услалтын системийг бүрэн сэргээж, худаг, булаг шанд, цас борооны ус ашиглаж, тэжээлийн ургамал тариалан, өвс хадлан бэлтгэж байгаа иргэд, аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын зээл тусламжид хамруулах
- Малчид, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн чанартай, хямд үнэтэй тэжээлээр хангаж, хадгалалт борлуулалтын цэгүүдийг аймаг, суманд байгуулах
- Монгол малын тэсвэрт чанарыг бататган, биологийн боломжийг нь бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлэх
- Малын чанар, үржлийн ажлыг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх
- Малчдын өрхийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох фермерийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих

- Өндөр ашиг шимт суурин, хагас суурин аж ахуйг олноор бий болгох, малыг био технологийн аргаар үржүүлэхэд онцгойлон анхаарах, адуу, ямааны мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн:

- Бэлчээрийн газрын талхагдлын хэмжээ буурна
- МАА-н салбарт шинэ техник тоног төхөөрөмж нэвтэрч, тэжээлийн хангамж дээшилж, эрсдэл даах чадвар нэмэгдэнэ
- Малын таваарлаг чанар дээшилнэ.

4. Газар тариалангийн салбарын хөгжлийн бодлого

Стратегийн зорилт 1. | 2008-2015 он | Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэнд оруулж, усалгааны асуудлыг шийдвэрлэнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Атаршсан тариалангийн талбайг иргэд, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах
- Инженерийн хийцтэй услалтын системийн ашиглалтыг сайжруулж, усалгааны норм, горим, тариалалтын технологийг чандлан мөрдөж, ургамлын сэлгээ, ээлжлэн тариалах систем тогтоож, хөрсний үржил шимийг сайжруулах
- Энгийн болон уламжлалт аргаар үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд услах боломжтой талбайг түлхүү эзэмшүүлэх,
- Усалгааны суваг шуудуу шинээр гаргах, сэргээн засварлах зэргээр талбайн ашиглалтыг сайжруулах, усалгааны хуваарь, горим мөрдөх
- Газар тариалан эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар эзэмшүүлэх, өмчлүүлэх замаар газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх
- Энгийн болон инженерийн хийцтэй услалтын системийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж, дэс дараатай сэргээн засварлаж, бүрэн ашиглах
- Энгийн услалтын системийг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан, сэргээн засварлаж, иргэдэд эзэмшүүлэх замаар хадлан, тариалангийн талбайг нэмэгдүүлэх
- Усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг бүх талаар дэмжиж, техник тоног төхөөрөмжийг урт хугацаатай, бага хүүтэй зээл, лизингээр олгох
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй шим бордоо хэрэглэж, нэг га-гийн ургацыг нэмэгдүүлэх
- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг айл өрх, албан байгууллагуудаар тариалуулж, амьдрал ахуйдаа хэрэглэхийг дэмжиж сайн чанарын үр суулгацаар хангах арга хэмжээг дэс дараатай авч, “Хүлэмж”, “Зоорь” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Өрхийн аж ахуйн гар ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортлодог болон дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих
- Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, чацаргана, жимсний тариалалтыг өргөтгөх

Хүрэх үр дүн:

Тариалах талбайн хэмжээ , газар тариалагийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нэмэгдэх нөхцөл боломж бүрдэнэ

Иргэдэд газар тариалан эрхлэх боломж нөхцөл сайжирч, усалгаатай талбайн хэмжээ нэмэгдэнэ.

Стратегийн зорилт 2 | 2016-2021 он |Орон нутгийн хөрс, уур амьсгалд тохирсон хүнс, тэжээлийн таримлын нэр төрлийг олшруулж, тэдгээрийг нутагшсан сортын үрээр хангах, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, сонгино зэрэг зарим төрлийн таримлын үр шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх

- Байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицсон, чанарын шаардлага хангасан, нутагшсан сортын үрээр хангах, үрийн нэр төрлийг олшруулж, сорт сорилын ажлыг эрчимжүүлэх, нутагшсан шинэ сорт бий болгох
- Эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллаж, түргэн боловсордог, өндөр ургацтай, чанарын шаардлага хангасан үрийг хэрэглэснээр таримлын нэр төрлийг олшруулах,
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, үр тариа, тэжээлийн таримлын ургацын 80-90 %-ийг усалгаатай талбайгаас хураан авч, үр тарианы 80, төмс, хүнсний ногоо, таримал тэжээлийн 100, жимс жимсгэний 60 %-ийг дотооддын үйлдвэрлэлээр хангах
- Газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулах
- Усан сан, хөв байгуулах, хөрсний гүний усыг ашиглах, гүний худаг, услалтын системийг шинээр барих, сэргээх зэргээр услалтын оновчтой системийг бий болгох

Хүрэх үр дүн:

Газар тариалангийн үйлдвэрлэл тогтворжиж, хүн амын хүнсний хангамж нэмэгдэнэ.

5. Хүнсний үйлдвэрлэлийн бодлого

Стратегийн зорилт 1 | 2008-2015 он | Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтыг боловсронгуй болгож бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хүн амыг зөв хооллох, эрүүл хүнс хэрэглэж хэвших, хорт зуршлаас хүн ардыг хамгаалахад чиглэсэн сургалт сурталчилгааг өргөжүүлэх
- Эрдэс шим бордоог ашиглаж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, хүний биед шим тэжээл өгөх уураг өндөртэй ургамлыг хүнсэнд хэрэглэх
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалтанд тавих хяналтыг сайжруулж, хяналтын сүлжээ бий болгох,
- Түүхий эд материал болон бэлэн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг шалгах иж бүрэн лабораторитой болох
- Худалдаа, нийтийн хоолны газрыг бүрэн аттестатчилж, тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох, үйлчилгээний ангилал зэрэглэл тогтоох, ажил үйлчилгээний стандартыг хатуу мөрдөх
- Уламжлалт аргаар боловсруулдаг сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд орчин үеийн техник технологи нэвтрүүлэх
- Жимс ногооны талбай, хамгаалагдсан хөрсний тариаланд дуслын болон нэвчих, мананжуулах, бороожуулах усалгаа зэрэг ус хэмнэх чийгшил бий болгох
- Сүү сүүн бүтээгдэхүүний тээвэрлэлт хадгалалт, борлуулалтын сүлжээ бий болгох, орчин үеийн техник тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулах
- Төв суурин газруудад хүнсний худалдааны төв байгуулж, ариун цэврийн шинжилгээ, хяналтын нэг цэгийн үйлчилгээг бий болгох
- Жимс жимсгэнэ, хүнсний ногоо, чацаргана, мал, амьтдын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрийг бий болгох, нөөшлөх, даршлах, хатаах зэрэг хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хүрэх үр дүн:

- Хүн амын хүнсний хангамж нэмэгдэж, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх боломж бүрдэнэ
- Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, эрүүл аж төрөх нөхцөл бүрдэнэ

Стратегийн зорилт 2 | 2016-2021 он| Хүнсний үйлдвэрлэлд өндөр технологийг тууштай нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөг, гахай, тахиа, загасны махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Экологийн цэвэр бүтээгдэхүүн болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Орчин үеийн техник, технологитой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангаж, гадаад зах зээлд нийлүүлэх.
- Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлыг олон улсын стандартын жишигт хүргэх.
- Боршоо, Хандгайтын боомтоор импортлогдож байгаа хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах
- Тохиромжтой бүс нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох
- Орон нутгийн олдоц сайтай түүхий эдийг түшиглэн, шим бордооны үйлдвэр байгуулах
- Хүнс, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл түгээх, шинэ технологи эзэмшүүлэх ХАА- н төвийн үйлчилгээг сайжруулах

Хүрэх үр дүн:

Хүний эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл бүрдэж, хүнсний аюулгүй байдал хангагдана.

6 Аялал жуулчлалын бодлого

Стратегийн зорилт 1 | 2008-2015 он | Аймагт аялал жуулчлал хөгжүүлэх сүлжээ бий болгож, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн дагуу бүсийн аймгуудтай хамтарсан “Увс-аялал жуулчлал” сүлжээ бий болгож, жуулчдын тоог нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын гол бүс нутгуудын харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх
- Жуулчин тээвэрлэлтийн болон жуулчин хүлээн авах байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Одот, цэцэгт зэрэглэлийн зочид буудал байгуулах зэрэг аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих.

Хүрэх үр дүн:

Жуулчдын бааз, ирэх жуулчдын тоо нэмэгдэж, байгаль орчинд халгүй, жуулчдын сонирхлыг татсан, аяллын шинэ төрлүүд бий болно.

Стратегийн зорилт 2 | 2016-2021 он | Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлж, аяллын төрлүүдийг бүс нутгуудаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх чиглэл:

- Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасган, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах
- Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Сонгосон газар нутагт нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын загвар бий болгож, түүний боломж, ашиг шимийг малчдад таниулах
- Жуулчдад зориулсан гарын авлага, танин мэдэхүй, сурталчилгааны материалыг хэвлүүлж гадаад дотоодод сурталчлах.
- Нутгийн иргэдийг аялагч, жуулчдад үйлчлэх чиглэлийн сургалтад хамруулан мэргэшүүлэх, жуулчдад бүтээгдэхүүнээ борлуулдаг хамтлаг, нөхөрлөлүүдийг дэмжих.
- Салбарын хүний нөөцийг бэлтгэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарах
- Увс-Баян өлгийгөөр дамжин, Казакстан, ОХУ, бусад орнууд руу аялах сувгийг нээх, маршруттай болгох зорилгоор танилцах аялал, уулзалт зохион байгуулж, санал солилцох

Хүрэх үр дүн:

- Аймгийн төсвийн болон ажил үйлчилгээний орлогод аялал жуулчлалын салбарын орлогын эзлэх хувийн жин өснө,

- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сүлжээ бий болж, төрөл, нөөц нэмэгдэж, тэр хэмжээгээр иргэдийн амьдралын түвшин дээшилнэ.

7, Дэд бүтцийн хөгжлийн бодлого

7.1. Тээврийн салбар

Стратегийн зорилт 1: | 2008-2015 он | Аймагт нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн нөхцөл, шаардлага хангалтын түвшинг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчдийг хувь иргэнээс хамтын удирдлага, хоршоолол, нөхөрлөл, төрийн өмч давамгайлсан байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хэлбэрт шилжихийг дэмжих
- Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд хийх хяналт оношлогоо, техникийн магадлал, баталгаажуулалтыг сайжруулах
- Нийтийн тээврийн ажил үйлчилгээг олон улсын стандартад хүргэж, дотоодын ачаа, зорчигч тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах
- Нийтийн тээврийн такси, автобус, сонирхогч байгууллага, иргэдийн автомашиныг хөдөлгөөнт нэвтрүүлэгч, мэдээлэл хүлээн авагч төхөөрөмжөөр тоноглох, тээврийн удирдлага, зохицуулалтыг автоматжуулахад дэмжлэг үзүүлэх
- Олон жижиг тээвэрлэгчдийг нэгтгэн төрөлжүүлж, авто замын хөдөлгөөнд удирдлага зохицуулалтын “Ухаалаг” тээврийн систем нэвтрүүлэх.
- Улс, хот хоорондын зам, тээврийн хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох, мэдээллийн систем, тээврийн хэрэгслийн байршил, зогсоол, хөдөлгөөнийг тодорхойлох, ажиллах хуваарь, үйлчилгээний төрөл, үнэ тариф зэрэг мэдээлэл олж авах боломж бүрдүүлсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх

Хүрэх үр дүн:

Нийтийн зорчигч тээврийн удирдлага, зохион байгуулалт, үйлчилгээний хүртээмж сайжирч, хувийн хэвшлийнхний үйлчилгээний төрөл нэмэгдэж жигдэрнэ.

Стратегийн зорилт 2 Авто тээврийн хэрэгслийн хүрээлэн байгаа орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс бууруулж, тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд стандартын шаардлага хангуулж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангана

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Улаангом хот, сумдын төв болон сум хоорондын замын тэмдэг, тэмдэглэгээг стандартын хэмжээнд хүргэх, замын хөдөлгөөний зохицуулалт, удирдлагын автоматжсан систем нэвтрүүлэх
- Тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжүүлэх
- Ачаа тээвэрт анхдагч эх үүсвэрээс эцсийн хэрэглэгч хүртэлх цаг хугацаанд болон орон зайд материалын ба мэдээллийн урсгал шилжих хөдөлгөөнийг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хянах, зохицуулах логистикийг нэвтрүүлэх
- Тээврийн үйлчилгээнд тээвэрлэлтийн үр ашигтай нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, бүсүүдийн төвд ачаа, тээврийн терминалыг байгуулах
- Авто замын барилга угсралт, засвар арчлалтын норм дүрэм, стандартыг боловсронгуй болгох
- Хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн үнэлгээ, шатахуун зарцуулалтанд шууд нөлөө үзүүлэх зарим эд ангийн техникийн үйлчилгээ, засварыг оношлогооны үр дүнг харгалзан хийдэг журамд шилжих
- Тээврийн хэрэгслийн бүтээлийг нэмэгдүүлэх, шатахуун зарцуулалтыг багасгах, шингэрүүлсэн шатдаг хий зэрэг хосолмол түлш хэрэглэдэг автомашинаар парк шинэчлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд туслах

Хүрэх үр дүн:

- Ачаа тээврийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, сөрөг тээвэр багасаж, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг хямдран, эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ.
- Автомашины техникийн хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, байгаль орчин экологийн тэнцвэрт байдал хамгаалагдана

Стратегийн зорилт 3 : Орон нутгийн замын сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, зарцуулалтыг оновчтой болгон, орон нутгийн зам, гүүрийг тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй байлгах, авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Авто замын салбарын хүний нөөцөд анхаарч, мэргэжилтэй ажилчид бэлтгэхийг бүх талаар дэмжих
- Орон нутгийн зам, гүүрийн арчлалт, хамгаалалт, засварыг жил бүрийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлэх
- Улаангом хотын доторхи болон хот орчны замыг өргөтгөх, шинэчлэх, замын гэрлэн дохиотой болгох
- Чингэлэгийн тээврийг хөгжүүлэх
- Авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж, эхний ээлжинд бүс, аймгийн төв, нийслэл хоттой хатуу хучилттай автозамаар холбох.
- Урд, хөрштэй холбогдох хатуу хучилттай замыг эхний ээлжинд шийдвэрлэх
- “Мянганы зам”-ын босоо тэнхлэгийн Гашууны гүүрээс Тээлийн гүүр хүртэлх хатуу хучилттай авто замыг барьж, цааш үргэлжлүүлэх.
- Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай аймгийн төвийг холбох
- Төв замын ойролцоох зарим сумдыг хатуу хучилттай замтай холбох

Хүрэх үр дүн

Сумдтай харилцах авто замын нөхцөл сайжирч, шатахуун бага зарцуулах тээврийн хэрэгслүүдийг ашиглах боломж бүрдэнэ.

Босоо хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай зам баригдана.

Стратегийн зорилт 4 Улаангомд нисэх онгоцны хатуу хучилттай зурвас барьж, нисэх буудалд дунд болон бага оврын агаарын хөлөг хүлээн авна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Улаангомоос 14 км зайд “ Хар усны эх”-д онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас барих.

Орчин үеийн авиа навигацийн тоноглолоор хангагдсан нисэх онгоцны буудлын цогцолбор барьж байгуулах

Буудлын үйлчилгээг дагалдах дэд бүтцийг хөгжүүлж, хоолны газар, зочид буудал барих

Агаарын тээврийн графикайг чанд мөрдөж, нислэгийн аюулгүй байдлыг дээшлүүлэх

Хүрэх үр дүн:

Нислэгийн болон нисэхийн аюулгүй ажиллагааг хангасан шинэ цогцолбор байгуулснаар хүлээн авах агаарын хөлгийн төрөл, тоог нэмэгдүүлж, зорчигчдод хөнгөн шуурхай үйлчилнэ.

Стратегийн зорилт 5 | 2016-2021 он | Нисэх онгоцны хатуу хучилттай зурвас бүхий олон улсын статустай нисэх буудал барьж том оврын агаарын хөлөг хүлээж авах, олон улсын агаарын шугам нээнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хатуу хучилттай зурвас өргөтгөх
- Улаанбаатар-Улаангом-Абакан-Улаанбаатар чиглэлд агаарын шугам нээх.
- Улаанбаатар-Улаангом-Кызыл-Улаанбаатар чиглэлд агаарын шугам нээх судалгаа хийх
- Сум болон аймаг хооронд агаарын шугам нээх
- Баруун туруун, Өмнөговийн аэровокзалыг ашиглалтанд оруулж, “Хар тэрмэс”-т зун, намрын улиралд ажиллах аэропорт нээх

Хүрэх үр дүн

Зорчигчдын үйлчилгээг сайжруулахын зэрэгцээ бизнес, аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

Стратегийн зорилт 6 Авто болон төмөр зам, замын байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, засвар арчлалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологийг чанд мөрдүүлж, техник технологийн шинэчлэлт хийх
- Улс, орон нутгийн чанартай замын засвар, арчлалт, авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг сайжруулах
- Авто замын мэргэжилтэй ажилтан, ажилчид бэлтгэх, сургалтын төв байгуулж, хүний нөөцийг сайжруулах
- Авто тюнинг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулж хэрэгжүүлж эхлэх.
- Улс хоорондын авто тээврийн үйлчилгээний хүрээ, сүлжээг өргөжүүлэх.
- Баруун бүсийг ОХУ, Хятадаас төмөр замын гарцтай болгох асуудлыг судлаж хэрэгжүүлж эхлэх

Хүрэх үр дүн:

Тээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээ, замын нөхцөл сайжирч, зам, тээврийн байгууламжийн хөгжлийн шинэ гарц нээгдэнэ.

7.2. Эрчим хүчний салбар

Стратегийн зорилт 1. | 2008-2015 он | Аймгийн бүх сум, малчдыг эрчим хүчээр хангаж, салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, аюулгүй байдлыг хангаж, эрчим хүчний системийн үр ашгийг сайжруулна

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төвлөрсөн эрчим хүчний системд холбогдоогүй сумдыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах
- “100000 нарны гэрэл” хөтөлбөрийн хүрээнд хөдөөний айл өрхүүдийг нар салхины эрчим хүчээр бүрэн хангах.
- Эрчим хүчний салбарт орчин үеийн тоног төхөөрөмжийн хангамжыг сайжруулах
- Улаангом хотын гэр хорооллын эрчим хүчний шугамыг шинэчлэн дулааны шинэ эх үүсвэрийг бий болгох
- Аймаг, сумын эрчим хүчний дотоодын нэгдсэн системийн үр ашгийг дээшлүүлэх.
- Эрчим хүчний урсгалыг зохицуулах орчин үеийн системийг бий болгож, өр, авлагыг барагдуулах.

Хүрэх үр дүн:

- Бүх сум байнгын цахилгаантай болж, малчин өрхүүд нар, салхины эрчим хүчээр хангагдана.
- Цахилгааны алдагдал буурч, өр авлагагүй болно.

7.3. Түлшний салбар

Стратегийн зорилт 1 | 2008-2015 он | Нүүрсний хийн бага оврын цахилгаан станцыг байгуулж, эрчим хүчний хангамжийг дээшлүүлэх, шатдаг хий ашиглах замаар түлшний эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Нүүрсний утаагүй түлш үйлдвэрлэх
- Хий гаргах, зөөх, цэнэглэх цэгийг олшруулж, үйлдвэрлэл болон ахуйд байгаль орчиндоо халгүй түлш ашигладаг болгох

Хүрэх үр дүн:

Байгаль орчинд хор хөнөөлгүй түлш хэрэглэдэг болно.

Стратегийн зорилт 2 | 2016-2021 он | Нүүрсний гүн боловсруулалтын бүтээгдэхүүн гарган авч, хэрэглээнд шилжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хар тарвагатайн ордыг түшиглэн, цахилгаан дулааны станц барина.

Хүрэх үр дүн:

Нүүрсний гүн боловсруулалт хийдэг үйлдвэртэй болсноор аймгийн эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах шинэ салбар бий болно.

7.4 . Мэдээлэл холбооны салбар

Стратегийн зорилт 1 | 2008-2021 он | Мэдээлэл холбооны технологийг нийгэм, эдийн засгийн бүх салбарт эрчимтэй нэвтрүүлснээр тус салбарын хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Мэдээлэл холбооны суурь сүлжээг тоон технологид бүрэн шилжүүлж, өндөр хурдны мэдээллийн орчин үеийн дэд бүтэцтэй болгох
- Мэдээлэл, холбооны салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих
- Сансрын хиймэл дагуулын суваг, системийг мэдээлэл, холбооны хэрэглээнд өргөн ашиглах
- Шуудан холбооны сүлжээг ашиглан, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж, сум, багийн шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх
- Бүх төрлийн мэдээллийн улсын нэгдсэн сан байгуулж (зам, тээвэр, аялал жуулчлал, хүн ам, газрын бүртгэл, байгалийн нөөц, боловсрол, соёл, архивын г.м) ашиглах
- Хөдөө орон нутагт мэдээллийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж, үүрэн телефон хэрэглэгчдийн тоог тууштай өсгөх
- Мэдээлэл холбооны технологийн үйлчилгээ, хэрэглээг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих нэг гол хэрэгсэл болгон хөгжүүлэх

Хүрэх үр дүн:

Бүх сумын төв висат системд холбогдож, гар утас, интернетийн харилцаанд бүрэн шилжинэ.

Мэдээлэл, холбооны технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын ахуйн хэрэглээнд өргөн нэвтрүүлнэ.

7.5. Хот байгуулалт, барилгын салбар

Стратегийн зорилт 1. | 2008-2015 он | Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо бүрдүүлж, хот байгуулалтыг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хот байгуулалтын эрх зүйн орчинг сайжруулж, хот төлөвлөлтийн норм нормативийг боловсронгуй болгох
- Хот суурин газрын гэр хорооллын хөгжлийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Улаангом хотыг тохижилт соёлжилтоороо үлгэр жишээ хот болгох зорилтыг хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн:

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Улаангом хот төлөвлөлтийн үндсэн чиглэлүүд хэрэгжинэ.

Стратегийн зорилт 2. Орчин үеийн чанарын шаардлагыг хангасан барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлж хүн амын орон сууцны хангамжийг сайжруулна

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарын хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн норм норматив, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох
- Барилга, барилгын материалын салбарт орчин үеийн техник, өндөр технологийг тууштай нэвтрүүлэх
- Улаангом, бусад сумдын төвд эхний ээлжинд дунд, бага орлоготой төрийн албан хаагчдыг “40000 орон сууц” хөтөлбөрт хамруулан, орон сууцаар хангах
- Сонирхсон иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох замаар орон сууцаар хангах, нөхцөлийг нь сайжруулах арга хэмжээ авч энэ чиглэлээр тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн:

- Барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанар дээшилнэ.

- Иргэдийн ялангуяа төрийн албан хаагчдын орон сууцны хангамж 10-20 хувь ахиж, амьдралын нөхцөл сайжирна.

Стратегийн зорилт 3 : | 2016-2021 он | Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Газрын мэдээллийн үндэсний системийг бий болгон иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллагуудын оролцоо, харилцаа жигдэрч, шуурхай үйлчилгээгээр хангагдах
- Аливаа эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлэх.
- Гэр хорооллыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож, оршин суугчдын орон сууцны нөхцлийг улам сайжруулах
- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг Газрын алба, хот байгуулалтын албаны чиг үүрэгтэй уялдуулан боловсронгуй болгох
- Орон нутгийн барилгын компаниудыг чадавхижуулахад анхаарч, барилгын мэргэжлийн ажилчдыг сургах, дадлагажуулахыг бүх талаар дэмжих

Хүрэх үр дүн:

- Иргэдийн эд хөрөнгийн бүртгэлийн ажил төгөлдөршинө.
- :Аймгийн барилгын компаниудын чадавхи өсөж, мэргэжилтэй ажилтан, ажилчдын тоо нэмэгдэнэ.

Стратегийн зорилт 4: Барилга угсралтын ажилд шинэ техник, өндөр технологийг тууштай нэвтрүүлж, барилгын шинэ нэр төрлийн материал хийцийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ..

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа :

- Өндөр орон сууц болон томоохон үйлдвэрлэлийн барилга барих үндэсний чадавхыг сайжруулах
- Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж нэр төрлийг нь олшруулах.

Хүрэх үр дүн:

Барилгын материалын үйлдвэр бэхжиж, шинэ техник технологи мөрдөгдөнө.

Гуравдугаар бүлэг

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгалийн төрх байдлыг хадгалах, байгалийн болон түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн хамгаалах, экологийн даацад нийцүүлэн, нөөц баялгийг нутгийн иргэдэд түшиглэн, зохистой ашиглах, хугацаа алдалгүй нөхөн сэргээх, үр өгөөжийг нь ард иргэдэд адил тэнцүү хүртээж, амьдралын найдвартай эх үүсвэртэй болгох нөхцөлийг бүрдүүлэх замаар аймаг, сумын эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэн, амьдрах орчныг сайжруулахад хөгжлийн бодлогын зорилго оршино.

1, Газар түүний хэвлийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, цөлжилттэй тэмцэх

Стратегийн зорилт 1, Газрын нөөцийн менежмент, хүний нөөцийн маркетингийг улам боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймаг сумдын хэмжээнд газрын нөөцийг нийгмийн тухайн үеийн эрэлт хэрэгцээг судлах, үнэлэх, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, талаар баримтлах бодлого боловсруулан сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, боловсон хүчнийг чадавхижуулж, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг дээшлүүлэх
- Аймгийн нутаг дэвсгэрийг кадастрын зургаар зурагжуулж, үндэсний мэдээллийн санд холбох

- Аж ахуйн нэгж байгууллага иргэдэд газар эзэмшүүлж ашиглуулж, өмчлүүлэхдээ тэгш, шударгаар шийдвэрлэж, хотын ерөнхий төлөвлөгөө баримтлан газрыг олгох
- Бэлчээрийн талхдалтыг багасгахын тулд төрийн болон орон нутгийн иргэд, малчдын хамтарсан менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх,
- Сум бүрийг аюулаас хамгаалах бэлчээрийн нөөцтэй болгох, мал хэт бөөгнөрсөн буюу бэлчээр талхлагдсан газруудыг системтэй ашиглах аргад шилжүүлэх
- Аймгийн хэмжээнд байгаа олон салаа замыг багасгаж хатуу хучилттай буюу сайжруулсан шороон замыг нэмэгдүүлж Хотгорын нүүрсний уурхайгаас Бөхмөрөн, Ховд, Өмнөговь сумуудын нутгийг дайран гардаг Ховд, Баянөлгий аймаг руу нүүрс тээвэрлэдэг олон салаа замыг багасгах
- Ашигт малтмалын хайгуулын болон технологийн туршилтын ажил хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн хайгуул олборлолтонд өртсөн, нөхөн сэргээлт хийсэн талбай бүрээр мэдээллийн сангийн бааз бий болгож, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах
- Ердийн ашигт малтмалыг лицензгүй талбайгаас авч ашиглахыг бүрэн зогсоож аймгийн хэмжээнд нөхөн сэргээлт хийх шаардлагатай газруудын нарийвчилсан судалгаа гаргаж бүрэн нөхөн сэргээлт хийж дуусгуулах
- Бэлчээрийн ургамал сүйтгэгч хортон мэрэгч, царцааны хэт олширлоос сэргийлэх, түүнтэй тэмцэх биологи болон механик аргаар устгах ажлыг эрчимжүүлэх
- Ховордож байгаа ургамал амьтны байршил нутаг болон аймаг, сумын нийгэм эдийн засагт чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг улс, аймаг, орон нутгийн хамгаалалтад оруулж нөхөн сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах
- Аймаг сумдын хэмжээнд цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, хөрсний үржил шимийн доройтол, элсний нүүдэл, хуурайшилт, цөлжилтийн явцын талаарх мэдээллийн нэгдсэн санг байгуулж үйл ажиллагааны чиглэл болгон ашиглах
- Цөлжилттэй тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах замаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж цөлжилтийг сааруулах тогтолцоог бий болгох
- Цөлжилтөд ихээхэн өртөгдсөн газрыг тодорхой хугацаанд ашиглалтаас чөлөөлөх, ургамалжуулах, мод бут тариалах ажлыг бүх талаар дэмжих, элсний нүүдэл бүхий сумын төв суурин газрыг “ногоон хэрэм” хамгаалалттай болгох

Хүрэх үр дүн:

Байгаль нийгмийн экологигсон харилцааны нөхцөл дэх газрын менежментийн онол, арга зүй төлөвлөлт, зохицуулалтын норм, нормативын баазыг бий болгож, газрын менежментийн арга ухааныг эзэмшсэн хүний нөөцтэй болно.

УТХГН-ийн сүлжээг өргөтгөж аймгийн нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамруулна.

Газар ашиглалтын бүтцэд өөрчлөлт орж цөлжсөн газрууд эргэн нөхөн сэргээж цөлжилтийн явц саармагжина.

2. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт

Стратегийн зорилт 2 Ойн нөөцийн тогтвортой ашиглалтын менежментийг сайжруулж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцлийг хадгалах нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Ойн нөөцийг аймаг, сумдын нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи эдийн засгийн үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах менежмент төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
- Аймгийн хэмжээнд ойн асуудлыг хариуцан ажиллах мэргэжлийн байгууллага ойн агентлаг, сумын болон сум дундын ойн ангиудыг байгуулж, боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр ханган, ойн аж ахуйн арга хэмжээ болох мод бэлтгэл, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажил, арчилгаа цэвэрлэгээний огтлолт, түймэр, хортон шавьжаас сэргийлэх, тэмцэх, үр түүх, боловсруулах, мод үржүүлэг зэрэг ажлыг бие даан мэргэжлийн түвшинд технологийн дагуу хийх ажлыг эрчимжүүлэх
- Ойн сангийн тодорхой хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлж, ойн нөөц баялгийг хариуцан хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, сурталчилах, ойн мэдээллийн сан байгуулж, мониторингийн сүлжээ

бий болгох замаар ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх

- Сумдын мод бэлтгэлийн ажлыг мэргэжлийн бригад, аж ахуйн нэгжүүдээр байгаль хамгаалагчийн хяналтын дор зөвхөн ойн цэвэрлэгээний журмаар хангадаг журамд шилжих
- Хүн амын түлшний хэрэгцээг мод орлох бүтээгдэхүүнээр солих, малчин айл өрхүүдийг утаагүй, түлшний хэмнэлттэй, хийн болон хорголон зуух ашиглахыг дэмжиж, харгана, бургас, шаваг зэрэг модлог бутлаг ургамлыг түлшинд хэрэглэх явдлыг багасгах иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой, модыг үнэлэн ойн санд худалдан авах замаар ногоон байгууламж, ойн сангийн талбайг нэмэгдүүлэх, чанар, үр дүнг сайжруулах ажлыг эрчимжүүлэх

Хүрэх үр дүн:

- Ойн нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх эрх зүйн орчин сайжирч ойн хэвийн өсөлт хангагдана.
- Ойн мэргэжлийн байгууллагын бүтэц тогтолцоо бий болж, хүний нөөц чадавхижиж, ойн аж ахуйн арга хэмжээ технологийн дагуу хийгддэг болно.
- Тодорхой ойн санг нутгийн ард иргэдэд гэрээгээр эзэмшүүлснээр ойн зөрчил багасч хамгаалагдана.

3. Усны нөөцийг ашиглах, хамгаалах

Стратегийн зорилт 3 Усны нөөц хомсдох, бохирдохоос урьдчилан сэргийлэх, экологи, хүний эрүүл мэндэд чухал ач холбогдолтой усыг хамгаалалтад авч гадаргуугийн болон гүний усны нөөцийг нэмэгдүүлж усны чанарыг сайжруулна

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Увс, Хяргас, Айраг, Ачит нууруудын бохирдлын судалгаа хийлгэж, хяналтын байнгын тогтолцоо бий болгох
- Нуур голуудын сав газрыг хамгаалахын тулд их хэмжээгээр хадлан бэлтгэх үйл ажиллагааг байгальд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр зохистой ашиглах арга технологи боловсруулж хэрэгжүүлэх
- Улаангом сумын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэн засварлаж горимын дагуу ажиллуулах, ус цэвэрлэх 2 дахь байгууламж барих
- Бороо, цас, шар усны үерийн усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж гадаргуугийн усны нөөцийг нэмэгдүүлж хадлан, тариалангийн талбайг усалж хүнсний ногоо, мод тариалах
- Хүн амын унд ахуй, эрүүл мэндэд өдөр тутам ашиглагдаж байгаа булаг, рашаан усыг улсын болон орон нутгийн хөрөнгөөр тохижуулах, хамгаалалтанд авах
- Тэс, Бөхмөрөн, Хөндлөн, Завхан, Ховд, Торхилог, Боршоо зэрэг томоохон голуудын усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах шинжлэх ухааны үндэслэл бүхий зөвлөмж гаргасны үндсэн дээр гол, мөрний сав газрын нэгдсэн менежментийг боловсруулж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн:

Гол мөрний сав газрын нэгдсэн менежментийн үйл ажиллагаа жигдэрч, усны эх үүсвэр, булаг, рашаанууд хамгаалалттай болж, гадаргын усны нөөц нэмэгдэж, усны чанар сайжирна.

4, Ан амьтан, биологийн төрөл, зүйлийг зохистой ашиглах, хамгаалах

Стратегийн зорилт 4 Увс аймгийн хэмжээнд нутгийн иргэдэд түшиглэсэн ан агнуурын менежмент бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймаг сумын хэмжээнд агнуурын болон ашигт ургамлын бүс нутаг тогтоох
- Ан агнуурын болон ашигт ургамлын нөөц бүхий тодорхой газар нутгуудыг байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэх
- Агнуурын амьтан, ашигт ургамал бүр дээр нөөцийн судалгаа хийх
- Тогтоогдсон агнуурын бүс нутгуудад агнуур зохион байгуулалт хийх

- Аймгийн хэмжээнд агнуурын менежмент төлөвлөгөө боловсруулах
- Агнуурын бүс нутаг, менежмент төлөвлөгөө, агнуур зохион байгуулалтыг үндэслэн аймгийн ИТХ ан агнуурын хуваарилалтыг суманд хийх
- Сумын байгаль хамгаалах санд агнуурын болон ашигт ургамал ашигласны төлбөрөөс хөрөнгө төвлөрүүлэх

Хүрэх үр дүн:

.Ан агнуурын нөөцийг зохистой ашиглахад нутгийн ард иргэдийн идэвхи оролцоо давамгайлж, тэдний ан агнуурын орлогоос тодорхой хишиг хүртэх менежмент төлөвшинө.

5. Агаар, хөрс, усны бохирдолт, хог хаягдлын менежмент

Стратегийн зорилт 5 Агаар, ус хөрсний бохирдолт, химийн бодисын хэрэглээг багасгах замаар амьдрах орчныг сайжруулахыг зорино.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хог хаягдлыг төрөлжүүлэх, ангилах, дахин боловсруулах, хог хаягдлын гарцыг бууруулах, тээвэрлэх, булаах, устгах ажлыг зохион байгуулалтанд оруулж хог хаягдалгүй зохистой хэрэглээг амьдралд хэвшил болгох.
- Хатуу хог хаягдлыг боловсруулах, байгальд халгүй технологитой үйлдвэртэй болох
- Арьс шир, өлөн, эсгий гэх мэт байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрийг төв суурингаас зайдуу байлгах бодлого баримталж хотын ерөнхий төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- Нам даралтын зуух, гэр хорооллын зуухуудыг нэгдсэн халаалтын төвлөрсөн системээр солих, түлш бага зарцуулах технологиор өөрчлөх
- Хот сууринд шинээр баригдах барилга байгууламжийг заавал ногоон байгууламжтай байхаар төсөвлөх.
- Байгаль орчны бохирдлыг тогтоох хэмжих лаборатори, багаж тоног төхөөрөмжтэй болох
- Химийн хорт бодисын хэрэглээг зааг ялгавартай бодлоготойгоор ашиглуулах

Хүрэх үр дүн:

Агаар, ус, хөрсний бохирдол буурч, өвчлөлийн тоо багасч хүн эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдэнэ.

6. Цаг уурын өөрчлөлтийн нөлөөлөл, сэргийлэх арга хэмжээ

Стратегийн зорилт 6 Ус, цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг өргөтгөн, хүчин чадлыг сайжруулах, автоматжуулах, байгаль цаг уурын эрсдлийг бууруулах, замаар эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Ус, цаг уур, байгаль орчны шинжилгээний ажлын хүчин чадлыг сайжруулах, өргөтгөх, автоматжуулах, ажиллагсдыг үе шаттай мэргэшүүлэх
- Орон нутагт интернет болон хиймэл дагуулын мэдээллийг ашиглан төрөл бүрийн мэдээллээр ард иргэдийг хангах
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Уур амьсгалын олон жилийн цуваа бүхий лавлах, мэдээллийн сантай болох
- Хөдөөгийн малчин айл өрхөд хүргэх мэдээллийг боловсронгуй болгох

Хүрэх үр дүн

Цаг агаарын бүх төрлийн мэдээний таарц, онч сайжирч, хэрэглэгч хүссэн мэдээллээ авах боломж бүрдэж эрсдлээс урьдчилан сэргийлэх нөхцөл сайжирна

Дөрөвдүгээр бүлэг

НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

1. Орон нутгийн эрх зүйн бодлого

Стратегийн зорилт 1. Төрийн байгууллагуудыг чадавхижуулан, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн чадамжийг сайжруулна

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Төрийн байгууллага, албан тушаалтнаас үйл ажиллагаандаа хууль, тогтоол шийдвэр, хөтөлбөр, зорилтыг хэрэгжүүлж ажиллах.
- Төрийн байгууллагуудын удирдлагын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах тогтолцоог бэхжүүлэх
- Хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хүртээмжтэй, ил тод болгон, хүний эрхийг дээдлэн хангах, шударга ёсыг чанд сахих зарчмыг мөрдүүлэх

Хүрэх үр дүн:

Орон нутгийн төрийн байгууллагуудын удирдлагын шийдвэрийн эрх зүйн үндэслэл хангагдаж биелэлт нь сайжирч, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа ил тод, хүртээмжтэй болно

Стратегийн зорилт 2 : Иргэдийн эрх зүйн боловсролыг төлөвшүүлэх, хүний эрхийг хангах орчин нөхцөл бүрдүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх эрх зүйн сургалтын тогтолцоог бий болгох
- Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх.
- Эрх зүйн туслалцаа үзүүлэх хувийн хэвшлийн байгууллага, иргэдийг дэмжих
- Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх
- Хүн хууль ёсны эрхээ эдлэхдээ бусдын эрх эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн хэв журмыг чанд сахих зарчмыг мөрдүүлэх
- Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ, сайн дурын хөдөлгөөний гаргасан санал санаачлагыг дэмжиж ажиллах

Хүрэх үр дүн:

- Иргэд хуулийг дээдлэн сахих, нийгмийн харилцаанд эрх зүйн мэдлэгтэй оролцох чадварыг эзэмшиж улмаар нийгмийн аливаа сөрөг үзэгдэл багасна.
- Хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, шударга ёсыг эрхэмлэдэг хандлага тогтоно.

Стратегийн зорилт 3: ГХУС ажлыг эрчимжүүлж, нийгэм дэх аюулгүй орчныг бүрдүүлнэ,

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, үр нөлөөг нь сайжруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Цагдаагийн байгууллагын чадавхи, шуурхай албыг бэхжүүлэх

Хүрэх үр дүн:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажилд ахиц гарч, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.

2. Төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэл

Стратегийн зорилт 1. Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлж, Ерөнхий менежерүүдийн манлайлал- менежментийн үр чадварыг дээшлүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратегийн төлөвлөлтийн чадамжийг бэхжүүлж, манлайлал, менежментийн үр чадварыг дээшлүүлэх
- Төрийн албаны гүйцэтгэлд үндэслэсэн удирдах чадавхийг бэхжүүлэх
- Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн албыг үе шаттайгаар цомхон чадварлаг болгож, зохистой хэмжээнд хүргэх
- Төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи нийгмийн аудитын арга зүйг нэвтрүүлэх

Хүрэх үр дүн:

Төрийн алба мэргэшсэн албан хаагчдаар бэхжиж, төсвийн ерөнхий менежерүүдийн манлайлал, менежментийн ур чадвар сайжирч, төрийн үйлчилгээний шат дамжлага багасаж, цомхон чадварлаг бүтэцтэй болно.

Стратегийн зорилт 2. Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Төрийн албаны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэх
- Төрийн албаны бүх шатанд боловсон хүчнийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах тогтолцоог бүрдүүлэх

Хүрэх үр дүн :

Төрийн албаны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадамж дээшилж , төрийн албан хаагчдын манлайлал сайжирна.

Стратегийн зорилт 3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх
- Төрийн албан хаагч бүрт хүний нөөцийн удирдлагын ур чадварыг эзэмшүүлэх
- Төрийн албан хаагчийг мэдлэг, боловсрол, туршлага чадварыг нь харгалзан томилох, дэвшүүлэх тогтолцоог бий болгох
- Иргэний бүртгэл мэдээллийн алба болон холбогдох бусад төрийн үйлчилгээний байгууллагуудыг ээлж дараатайгаар нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлэх
- Төрийн албан хаагчийн ёс зүйн кодексийг бий болгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих олон нийтийн тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх
- Төрийн албаны боловсон хүчний нөөцийг бүрдүүлдэг системийг бий болгож, төрийн албыг чадваржуулах
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн шинэ тогтолцоог бүрдүүлэх
- Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог гүйцэтгэл, үр дүнтэй нь оновчтой уялдуулан боловсронгуй болгох

Хүрэх үр дүн:

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, ажлын байрны стандартыг буй болгон түүнд хяналт тавих иргэд, олон нийтийн оролцоо дээшилнэ.
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим сантай болж төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалингийн тогтолцоо бүрдэнэ .

Стратегийн зорилт 4. Төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоно

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хууль тогтоомж суртачлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгаж, үр ашигтай зарцуулан сургалтын үр нөлөөг хянаж, мэдээлдэг тогтолцоог бий болгох
- Төрийн байгууллагын үйлчилгээнд нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх
- Төрийн байгууллагуудыг вэб хуудастай болгон нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбож, төрийн зарим гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлж энэ хуудсаар иргэдийн санал хүсэлтийг авдаг болох
- Багийн ажлыг компьютержүүлэх, мэдээллийг сүлжээгээр авах нөхцөл бүрдүүлэх
- Шүүх, прокурор, цагдаагийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгох

Хүрэх үр дүн

Төрийн байгууллагын чадавхи сайжирч, иргэдийн нийгмийн идэвжил дээшилнэ

3. Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллага

Стратегийн зорилт 1 Сумдыг эдийн засгийн чадамж, орон нутгийн онцлог тулгуурлан бүсчилэн хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Сумуудыг бүсчилэн хөгжүүлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Засаг захиргааны оновчтой, үр ашигтай, хүндээ хүрсэн бүтцийг бий болгох.
- Бүс нутгийн онцлог давуу талд түшиглэн аж ахуйн олон хэвшлийг хөгжүүлэх
- Багийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн:

Бүсийн хэмжээнд эдийн засгийн хөгжлийг бие даан хангах засаг захиргааны бүтэц тогтолцоо бүрэлдэнэ.

Стратегийн зорилт 2: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бие даан ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадварлаг цомхон бүтцтэй болгож иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Цахим мэдээллийн сан бүрдүүлж, цаасгүй мэдээллийн урсгалыг бий болгох
- Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг төлөвшүүлэх.
- НӨУЁБ-ын бие даасан байдлыг бэхжүүлэх

Хүрэх үр дүн:

Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагын цомхон чадварлаг бүтэц бий болж, төрийн албаны нэр хүнд дээшилж, мэдээ мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдана.

4. Хүн амын аюулгүй байдлын бодлого

Стратегийн зорилт 1. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангана

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх чиг баримтлах
- Хүнс болон бараа бүтээгдэхүүний шинжилгээний нэгдсэн лаборатори байгуулах;
- Хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийн бүрдүүлэлтэнд тавих хяналтын тогтолцоог бий болгох
- Хүнсний бүтээгдэхүүн хадгалах өндөр хүчин чадлын хөргөх систем бүхий зоорь байгуулах
- Импортоор орж ирж байгаа хүнс, бараа бүтээгдэхүүнд тавих хилийн хяналтыг сайжруулах, техник технологийг нэвтрүүлэх

Хүрэх үр дүн:

Хүн амын хүнсний хэрэглээний чанар, хүртээмж, нэр, төрөл, хангамж сайжирна.

Стратегийн зорилт 2. Хүн амын аюулгүй аж төрөх нөхцөл боломжийг бүрдүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

Хүн амыг болзошгүй террорист халдлагаас хамгаалах тогтолцоог бий болгох

Орон нутагт байгаа гадаадын болон харьяалалгүй иргэдийн эрх зүйн байдалд хяналтыг хэрэгжүүлэх

Химийн хорт болон тэсэрч дэлбэрэх бодисыг хэрэглэх, ашиглах, тээвэрлэхэд тавих хяналтыг хэрэгжүүлэх

Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөөцийг бүрдүүлэх

Хүрэх үр дүн:

Хүний аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажна.

5. Батлан хамгаалах бодлого

Стратегийн зорилт 1: Орон нутгийн хамгаалалтанд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бодлого зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх

- Аймгийн стратегийн хөгжлийн хөтөлбөрийг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх
- Цэргийн насны эрчүүдийг эрүүлжүүлэх, чадваржуулж, цэргийн болон дайчилгааны бие бүрэлдхүүний бэлэн байдлыг хангах
- Орон нутгийн улсын дайчилгааны нөөцийг 30-50%-д хүргэх
- Цэргийн дайчилгаагаар нөхөн хангах техник бие бүрэлдэхүүнийг бэлэн байлгах, тэдгээрийн сургалтыг байнга зохион байгуулж хэвших.

Хүрэх үр дүн:

Орон нутагт тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог бий болгож, бүс нутагт өөрийгөө хамгаалах үндэс бүрэлдэн тогтох нөхцөл бий болно.

6. Онцгой байдлын бодлого

Стратегийн зорилт 1: Гамшгийн удирдлагыг боловсронгуй болгож, гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Иргэд олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх
- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний оновчтой механизмыг хэрэгжүүлэх
- Гамшгийн мэдээлэл холбооны сүлжээг боловсронгуй болгож мэдээллийн сан бүрдүүлэх
- Аврах, гал унтраах анги, салбарын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмжийн хангалтыг сайжруулах, нэмэгдүүлэх
- Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүнийг шаардлагатай нарийн мэргэжилтэн, сумын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн мэргэжилтэнтэй болох

Хүрэх үр дүн:

Гамшгийн эмзэг байдал, эрсдэл буурна.

7. Гадаад харилцаа

Стратегийн зорилт 1: Хөрш болон дэлхийн бусад орнуудтай гадаад харилцааны идэвхитэй бодлого хэрэгжүүлэн хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- ОХУ –тай бүх талын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, БНХАУ-ын ШУӨЗО- ны аймаг хоттой шууд харилцааг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх ,
- Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж шууд харилцаатай хот мужийн тоог нэмэгдүүлэх.
- ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, АНУ, Турк болон дэлхийн бусад хөгжилтэй орнуудад боловсон хүчнийг бэлтгэх давтан сургах мэргэшүүлэх замаар дэлхийн шилдэг техник технологи эзэмшүүлэх

Хүрэх үр дүн :

Харилцаа хамтын ажиллагаатай улс орон, муж хотуудын тоо нэмэгдэж, дэлхийн шилдэг техник технологийг хэрэглэнэ.

Стратегийн зорилт 2: Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Эдийн засгийн гадаад харилцааны олон талт бодлого хэрэгжүүлэх
- Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх
- Байнгын ажиллагаатай хилийн боомтуудын материаллаг баазыг бэхжүүлэн олон улсын статустай болгох
- Хөрш орнуудын хилийн яармаг худалдааг өргөжүүлэн, Боршоо боомтыг эдийн засаг, худалдааны чөлөөт бүс болгох
- Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрийг нэмэгдүүлэх бодлого баримтлах
- Оросын холбооны улсын зарим хотуудтай агаарын шугамаар холбогдож , харилцаагаа өргөжүүлэх

Хүрэх үр дүн:

Аймгийн бүх салбарт гадаад харилцаа эрчимжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсан байна.

Тав дугаар бүлэг.**ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ**

Хөгжлийн стратегийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг оновчтой удирдлага, зохион байгуулалтаар хангах, дотоод гадаад таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зүй зохистой ашиглах, олон нийтийн оролцоог зөв сонгон хэрэглэх зэрэг нийтлэг арга хэрэгслийг зөв зохион байгуулж ажиллах нь аймгийн стратегийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн.

1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан зөвлөлийг аймаг сумын хурлын дэргэд ИТХ-ын даргаар ахлуулан байгуулж стратегийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудын хэрэгжилтэнд хяналт тавих, уялдуулан зохицуулах, санхүүжилтыг нь шийдвэрлэх, шаардлагатай үед нэмэлт судалгаа тооцоо хийж, хөтөлбөрт өөрчлөлт, тодотгол оруулах, зарим ажлыг нь хариуцан гүйцэтгэх үүрэгтэйгээр ажиллуулах
- Стратегийн хөтөлбөрийн асуудал хариуцсан зөвлөлийн дэргэд эдийн засгийн, нийгмийн, байгаль орчны гэх мэт асуудал эрхэлсэн мэргэжлийн ажлын хэсгийг байгуулж хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаар мэргэжлийн дүгнэлтүүд гаргуулж хөтөлбөрийн хэрэгжилтэнд авч ашиглаж байх
- Зөвлөл нь ажлаа жил жилийн улс аймаг, сумын төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүд, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аймгийн тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилт, бүс нутгийн хөгжлийн хөтөлбөртэй нягт уялдуулах
- Орон нутгийн Засаг захиргааны байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шууд удирдан зохион байгуулж уг хөтөлбөрт тусгасан зорилтуудыг шийдвэрлэх, тодорхой хугацаатай график, төлөвлөгөө боловсруулан тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллага, аж ахуй нэгж иргэд, ТББ-дад хариуцуулж, хөтөлбөрийн биелэлтэнд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Орон нутгийн захиргааны байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад үүсэж гарсан шинэ асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, гэрээ, дэд хөтөлбөр боловсруулах, гадаад хандив зээл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Стратегийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг бүсийн зөвлөл, Засгийн газрын үйл ажиллагааны | яам, агентлагуудын | хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй оновчтой уялдуулан зохицуулах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хариуцах эзэн, хугацаа, шаардагдах санхүүгийн эх үүсвэрүүдийг бодитой тооцож гаргах
- Хөтөлбөрийн зорилтуудыг улс аймаг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтууд, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй нягт уялдуулах, Засгийн газар, улс төрийн намууд, баруун бүс, УИХ-ын гишүүдийн болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах хэлбэрээр оновчтой уялдуулан зохицуулах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замын талаархи асуудлаар иргэдийн дунд болон иргэний нийгмийн хүрээ, шийдвэр гаргадаг субъектүүдийн түвшинд сургалт явуулж хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан оновчтой арга саналуудыг ашиглаж байх
- Эдийн засаг, нийгэм, байгаль орчны гэх мэт хүчин зүйлсийг уялдаа холбоотой авч үзэж шийдвэр гаргах түвшинд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийг үр ашигтай оролцуулах арга хэлбэрийг бий болгох

- Мэргэжлийн баг, эрдэмтэн судлаачдын хүчийг нэгтгэсэн нутгийн эрдэмтэд, мэргэжилтэнгүүдийн холбоо байгуулж аймаг сум, багийн өмнө тавигдаж байгаа ойрын болон хэтийн асуудлыг шийдвэрлэхэд тэдний нэгдсэн хүч бололцоо, оюуны чадавхийг ашиглах
- Стратегийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэд, иргэдийн нийгмийн оролцоог оновчтой ашиглах тэдгээрийг хөхүүлэн дэмжих арга менежментийг бий болгох
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр богино хугацааны төрөлжсөн төсөл хөтөлбөр, мастер төлөвлөгөө төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх
- Макро түвшний нэгжүүдийн үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлтэй оновчтой уялдуулах
- Хөтөлбөрийг олон нийтэд суртчилах, тайлбарлан таниулах, дутагдаж байгаа эх үүсвэрийг бүрдүүлэх талаар олон нийтийн санал санаачлагыг өрнүүлж хөтөлбөрийг дэмжих сан байгуулж үр дүнтэй оновчтой ашиглах
- Хувийг хэвшлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд эдийн засаг, эрх зүйн таатай орчин бий болгох, хөгжлийн хөтөлбөрийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон заалттай зөрчилдөж байгаа зарим хуулиудад шинээр нэмэлт найруулга оруулах талаар Засгийн газар, УИХ-д саналаа боловсруулан тавьж байх.
- Хөтөлбөрийн зарим зорилтуудыг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх хэлбэрийг өргөн ашиглах
- Сум, баг, байгууллага бүрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй болгох
- Хувийн хэвшлийн төлөвлөлтийг энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор эдийн засаг, эрх зүйн оновчтой механизм хөшүүргүүдийг бий болгох
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ үнэлгээг тогтмол хийж, давуу талуудаа бататгах, сул талуудаа саармагжуулах, засаж арилгах арга хэмжээ авч байх

2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл

- Хүн ардынхаа оюуны чадавхид тулгуурлан хөгжих бодлогыг тууштай баримтлаж өндөр хөгжилтэй орнуудад нарийн мэргэжлийн боловсон хүчин, инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг олноор бэлтгэх
- Эдийн засаг, санхүүгийн хөшүүргүүдийн тусламжтайгаар экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг түлхүү дэмжих
- Өндөр хөгжсөн болон түргэн хурдацтай хөгжиж байгаа орнуудын туршлагыг бүтээлчээр хэрэглэх.
- Эдийн засгийн өсөлтийг өндөр технологид суурилсан уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлтөөр хангах чиглэл баримтлах
- Экспортыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтаар дэмжих салбарын зарчим баримтлах
- Чадварлаг үйлдвэрлэгчдийг бий болгож тэдгээрийн бүтээгдэхүүнийг амжилттай борлуулах боломж нөхцлийг бүрдүүлэх бодлого баримтлах
- Үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх, ажиллах хүчний багтаамж ихтэй өөрийн түүхий эд нөөц давуу талд тулгуурласан эцсийн бүтээгдэхүүн үйлдэрлэдэг жижиг дунд үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлэх бодлого боловсруулаж хэрэгжүүлэх
- Дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, гааль татварын зохицуулалтыг оновчтой болгох арга хэмжээ авах
- Экологийн цэвэр технологи дамжуулах, оруулах бодлогыг дэмжин тэтгэх
- Хөрш зэргэлдээ улс, аймгийн эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх таатай орчныг бүрдүүлж, гадаад дотоодын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг эрж олох оновчтой ашиглах
- ОХУ, БНХАУ-тай хил орчмын худалдаа, хамтын үйлдвэр, худалдааны чөлөөт бүс байгуулах зэргээр хамтран ажиллаж эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах арга хэрэгсэл болгох зорилгоор хамтын ажиллагааг өргөтгөх
- Үнэт цаас, хөдөлмөрийн зах зээлийг оновчтой хөгжүүлэх

- Орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээг дэмжсэн эдийн засгийн урамшуулалын хөшүүргүүдийг бий болгох.
- Гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих, хөрөнгө оруулалтыг татах механизмыг бүрдүүлэх, Засгийн газарт олгож буй зээл буцалтгүй тусламжаас хүртэх боломжуудыг эрж хайх
- Орон нутгийн нөхцөл боломжийг бүрэн ашиглаж орлогыг нэмэгдүүлэх, оновчтой ашиглах механизмыг бий болгох
- Аймгийн эдийн засаг нийгмийн гол асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцэхийн өмнө ард иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, санал бодлыг нь тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх олон нийтийн оролцоо, тавих хяналт

- Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах
- Орон нутгийн байгалийн нөөц, баялалыг зүй зохистой ашиглах, байгал орчныг хамгаалах, эдийг засаг ниймийн хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, уугуул иргэдийн оролцоо хамтын ажиллагааг уялдуулах
- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, уугуул иргэд малчид тариаланчдыг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах
- Аймаг, сумын тулгамдсан асуудал, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд залуучуудыг өргөн оролцуулах оновчтой хөшүүрэг бий болгох
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, эрдэмтэдийн судалгаа шинжилгээний оролцоог нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх
- Иргэний нийгмийн байгууллагуудын зохион байгуулалтанд ороогүй хэсэг, ялангуяа хөдөө орон нутгийн иргэдийн оролцоо, иргэдийн нийгмийн идэвхийг хөгжүүлэх, нийгэм эдийн засаг, улс төрийн харилцаанд ороход сургах, иргэний боловсролыг өргөн хүрээтэй олгоход анхаарах
- Үйл ажиллагааны үр дүн, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор ижил чиглэлийн ТББ-ууд эвсэж, эсвэл холбооны хүрээнд ажлаа уялдуулах, тодорхой асуудлаар ТББ-ууд ажлын хэсгийн хэлбэрээр хамтран ажиллах зэрэг шинэлэг үйл ажиллагааг дэмжих
- Иргэний байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, мэдээллийн урсгалыг сайжруулахад иргэний нийгмийг татан оролцуулах
- Эдийн засаг нийгэм, байгаль орчны хөндлөнгийн хяналтыг олон нийтийн хяналтанд шилжүүлэх
- Бүх шатны иргэдийн хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж нөхцлийг хангах
- Иргэн бүр орлого олж татвар төлдөг зах зээлийн хуулийг амьдралд хэрэгжүүлэх зорилтыг иргэн бүрт хэвшүүлэх
- Төрийн албан хаагчид түүнчлэн ТББ, бизнесийн байгууллагын боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, сургаж бэлтгэх бичил хөтөлбөр боловсруулан, боловсон хүчний чадамжийн стандартыг бий болгож мөрдөх

4, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн эцсийн үндсэн үр дүн

- Стратегийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд Увс аймаг баруун бүсэд түлш, аж үйлдвэр, газар тариалан, худалдаа үйлчилгээний томоохон төв болж улмаар өөрийгөө санхүүжүүлэх эдийн засагтай болно.
- Эдийн засгийн бодит өсөлт улсын дундаас хурдтай хөгжиж өсөж, боловсруулах үйлдвэрийн хувийн жин ихээхэн нэмэгдэнэ.

- 2021 он гэхэд 1 хүнд ноогдох ДНБ улсын дундаж түвшинд хүрч хүмүүсийн аж амьдрал эрс сайжрах болно.
- Аймгийн эдийн засгийн бүтцэд ХАА-н болон уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэр, аялал, жуулчлал, түлш эрчим хүч, дэд бүтцийн салбар голлох хувийг эзлэх болно
- Хүн амын өсөлтийг хангах нөхцөл бүрэлдэж, хүний амьдралын үзүүлэлтүүд чанаржин хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд хүрнэ.

5. Шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэр

- Стратегийн хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн нөөц санхүүгийн эх бүхий л боломжтой эх үүсвэрийг ашиглахаар тооцоолсон болно.
- Гадаад эх үүсвэрт шууд хөрөнгө оруулалтаас гадна Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагчдын хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийг ашиглана.
- Шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажиллагааг улсын төвлөрсөн төсөв, аймгийн төсвөөс санхүүжүүлнэ.
- Стратегийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг Монгол улсад байгуулагдах Хөрөнгө оруулалтын банк, Хөрөнгө оруулалтын сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан зэрэг бусад боломжит эх үүсвэрийг ашиглана.
- Шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэхэд дор дурдсан эх үүсвэрийг ашиглах чиглэл баримтална. Үүнд:
 - Дотоодын банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах
 - Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих
 - Хуримтлал бий болгох, хүн амын сонирхлыг хөхүүлэн дэмжих, бэлэн мөнгийг төвлөрүүлэн ашиглах механизм, эдийн засгийн урамшууллын тогтолцоог бий болгох
 - Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох
 - Үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах хөшүүргийг боловсронгуй болгох
 - Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх
 - Бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөө бүхий төслүүдийг санхүүжүүлэх зориулалттай “Бүс нутгийн хөгжлийн сан” байгуулж ажиллахыг идэвхтэй дэмжих
 - Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэн хамтарсан үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулах